



Улс төрийн мэдээллийн агуулгад жендэрийн тэгш байдлыг хангах нь

Редакцуудад зориулсан удирдамж





ОРОЛЦЬЁ ТӨЛӨӨЛЬЕ

МЭДРЭМЖТЭЙ МЭДЭЭЛЬЕ

Улс төрийн мэдээллийн агуулгад
жендэрийн тэгш байдлыг хангах нь
Редакцуудад зориулсан удирдамж

Энэхүү удирдамжийг Хэвлэл мэдээллийн зөвлөл боловсруулж “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслийн санхүүжилтээр хэвлэв.

Бүтээлд илэрхийлсэн үзэл санаа, дүгнэлт нь зохиогчдынх бөгөөд төслийн санхүүжүүлэгч БНСУ-ын КОЙКА Олон Улсын байгууллага болон хэрэгжүүлэгч НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно.

Удирдамжийг боловсруулсан Д.Мөнхчимэг

Хянан тохиолдуулсан Э.Энэрэл, Э.Эрдэнэчимэг

Эх бэлтгэл, график дизайныг Анлимитэд Медиа группийн хамт олон гаргав.

Улаанбаатар хот, 2022 он

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	4
“Мэдрэмжтэй Мэдээлье” нэгдлийн танилцуулга	5
Яагаад бидэнд жендэрийн линз хэрэгтэй вэ?	7
Чанартай, ёс зүйтэй сэтгүүл зүй	8
Уншигч, үзэгч, сонсогчдын итгэлийг олж авах боломж	9
Бизнесээ өргөжүүлэх гарц	9
Ардчиллыг бэхжүүлэхэд оруулж буй хувь нэмэр	10
Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо тулгамдсан асуудал болох нь	11
Эмэгтэйчүүдийн улс төрийн эрх мэдэл сул байгааг харуулах найман баримт	11
Шинэ дуу хоолой: Эх сурвалжийн хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах нь	13
Хэвлэл мэдээлэл эмэгтэйчүүдийг үл тоомсорлож байгааг харуулах зургаан баримт	14
Цонх: Эх сурвалжийн гурван түвшин	14
Тренд: Олон улсын шилдэг туршлагауд	16
Цонх: 50:50 төслийн танилцуулга	17
Миранда Холт: Монголын хэвлэл мэдээлэл бидэнд хандаж байгаад баяртай байна	18
Зөвлөмж: Эх сурвалжийн хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах тал дээр редакцын хэрэгжүүлэх стратеги	19
Эмэгтэй мэргэжилтнүүд эх сурвалж болохоос татгалздаг есөн шалтгаан: Тэднийг хэрхэн татан оролцуулах вэ?	22
Б.Халиун: Эх сурвалжийн дата сан сэтгүүлчдэд хэрэг болно гэдэгт итгэлтэй байна	23
Мэдрэмжтэй өнцөг: Жендэрийн хэвшмэл ойлголтыг халах нь	25
Эмэгтэй улс төрчийг хэвшмэл ойлголтын дагуу харуулдаг нийтлэг таван алдаа	26
Зөвлөмж: Сэтгүүл зүйн бүтээлээр дамжуулан жендэрийн хэвшмэл ойлголтыг халах нь	27
Зураг дүрсээ мөн анхаараарай	28
Зөвлөмж: Эмэгтэй улс төрчийн хөрөг зургийг хэрхэн мэдрэмжтэйгээр авах вэ?	28
Өөрчлөлтийн эхлэл: Жендэрийн тэгш байдлыг хангахад “хоточ нохойн” үүрэг гүйцэтгэх нь	30
Шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн тэгш бус байдлыг хэвлэл мэдээллийн аженда болгох нь	31
Цонх: MPRESS.MN сайтын редакцын бодлогын хэсгээс	32
О.Ариунбилэг: Бид контент бүрдээ жендэрийн тэгш байдлыг анзааран ажиллах болно	33
Зөвлөмж: Шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн тэгш болон тэгш бус байдлын сэдвийг сурвалжлах нь	35
“Мэдрэмжтэй мэдээлье” редакцын менторшип хөтөлбөр	36
GoGo.mn олон ургалч байр суурийг хүргэх “Тэнцвэр” санаачилгыг эхлүүлж байна	37
Р.Адъяасүрэн: Бүртгэл хөтөлж эхэлснээр бид үнэлж, дүгнэж, өөрчлөх боломжтой болсон	39
“Зууны мэдээ” сонин эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжин ажиллана	40
Х.Мөнхжаргал: Жендэрийн эрх тэгш байдлыг хангахаар нийтлэлийн бодлогодоо тусгасан	41
ХАВСРАЛТ	42
Хавсралт 1. Жендэрийн нэр томъёоны товч тайлбар	42
Хавсралт 2. Редакцын жендэрийн мэдрэмжтэй байдлыг үнэлэх чеклист	42
Хавсралт 3. Сэтгүүл зүйн бүтээлийн чанарыг хянах редакторын чеклист	44
Хавсралт 4. Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим	44
ЭХ СУРВАЛЖ:	48

ӨМНӨХ ҮГ



Г.Гунжидмаа
Хэвлэл мэдээллийн зөвлөлийн
гүйцэтгэх захирал

1924 онд анхдугаар Үндсэн хуулиа батлахдаа л эмэгтэйчүүдийн сонгох, сонгогдох эрхийг хуульчилсан Азийн анхны улс болсон бахархалт түүх монголчууд бидэнд бий. Гэвч шийдвэр гаргах түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг хангах замдаа олсон амжилтаа бид бататгасангүй. Олон улсын парламентын холбооноос сар бүр шинэчлэн гаргадаг Парламент дахь эмэгтэйчүүдийн жагсаалтаас үзэхэд Монгол Улс 185 орноос 135-дугаарт эрэмбэлэгдэж байна. УИХ-ын гишүүдийн 17 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байгаа гэсэн үзүүлэлт хоёр сонгууль дараалан өссөнгүй. Гэтэл Азийн дундаж 20 хувь, дэлхийн дундаж 25 хувиас дээш гарлаа.

Бодит байдлыг сурвалжлан мэдээлэхдээ хэнийг ч ялгаварлан гадуурхалт болон хэвшмэл ойлголтын золиос болгохгүй байх нь хэвлэл мэдээллийнхний мэргэжлийн, ёс зүйн шаардлага. Гэвч сэтгүүл зүйн агуулгад эмэгтэйчүүдийн дуу хоолойг тэнцвэртэйгээр хүргэх, жендэрийн хэвшмэл ойлголтуудыг халах тал дээр алдаа дутагдал элбэг гарч байна. Улс төрийн мэдээллийн арван эх сурвалж тутмын нэгийг л эмэгтэйчүүд бүрдүүлж байгааг бидний хийсэн судалгаа харуулсан. Мөн эмэгтэй улс төрчдийг гадаад төрх, хүйс, хувийн амьдрал болон гэр бүлийн байдал зэргээр нь дүрсэлж, улс төрийн байр суурь, үйл ажиллагааг нь хойш тавих хандлага ажиглагдсаар байна. Энэ нь эх сурвалжаа ялгаварлахгүй, ижил тэгш хандах сэтгүүл зүйн зарчимд үл нийцэхээс гадна эмэгтэйчүүдийн сонгуульт албан тушаалд ажиллах урам зоригийг мохоодог саад тотгоруудын нэг болжээ.

Ардчилсан нийгэмд иргэдийн, тэр дундаа нийгмийн олон талт бүлгүүдийн идэвхтэй оролцоо хамгийн чухал байдаг. Тиймээс ч ардчиллыг бүрэн утгаар нь хэрэгжүүлэхийн тулд шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн

тэнцвэрт байдлыг хангаж, хүн амын тэн хагас болох эмэгтэйчүүдийн төлөөллийг оролцоулах шаардлагатай. Үүнийг олон нийтэд ойлгуулахад хэвлэл мэдээллийн салбар, сэтгүүлчид манлайлан оролцох нь чухал юм.

Иймд, “Мэдрэмжтэй мэдээлье: Улс төрийн мэдээллийн агуулгад жендэрийн тэгш байдлыг хангах нь” удирдамжийг Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс боловсруулан гаргалаа. Энэ ажлыг хийхэд туслалцаа үзүүлэн хамтран ажилласан Анлимитэд Медиа групп, хувь нэмэр оруулсан ВВС-гийн 50:50 төсөл, олон улсын “Internews” ашгийн бус байгууллага болон дотоодын редакцууд, сэтгүүлч, редакторууддаа талархал илэрхийлье.

Ташрамд дуулгахад, “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслийн хүрээнд Хэвлэл мэдээллийн зөвлөл, Анлимитэд Медиа группийн хамтарсан консорциумаас 2021 оны арваннэгдүгээр сард “Мэдрэмжтэй мэдээлье” нэдлийг үүсгэн байгуулсан. Нэгдлийн зүгээс сургалт, уулзалт, үйл явдлуудыг байнга зохион байгуулж байгаа бөгөөд 500 гаруй сэтгүүлч, редакторуудыг амжилттай хамруулаад байна.

Жендэрийн тэгш байдалд дэлхий нийт улам ихээр анхаарлаа хандуулж байгаа өнөө үед олон улсын нэр хүндтэй хэвлэл мэдээллийн байгууллагуудын хувьд жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүй нь шинэ чиг хандлага болж буй. Хэвлэл мэдээллийн агуулгад жендэрийн тэгш байдлыг хангах нь амаргүй ажил. Гэвч идэвх санаачилга, хичээл зүтгэл гарган үүнийг хийснээр сэтгүүл зүйн бүтээлээ илүү тэнцвэртэй, бодитой, чанартай болгож, уншигч, үзэгч, сонсогчдынхоо итгэлийг хүлээх боломжтой. Та бүхнийхээ ажилд амжилт хүсээд, хамтран ажиллахдаа үргэлж таатай байна гэдгээ уламжилъя!

ЗОРИЛГО

“Мэдрэмжтэй мэдээлье” нэгдэл нь жендэрийн мэдрэмжтэй, ёс зүйтэй, сэтгүүлч, редакторуудын мэдлэг, чадвараа сайжруулах, харилцан туршлага солилцох, салбартаа манлайлах, уншигч, үзэгчдийнхээ итгэлийг хүлээх нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилготой. Нэгдлээс шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн тэгш бус байдлын асуудлыг даацтай мэдээлэх, нийгэм дэх хэвшмэл буруу ойлголтыг халахад чиглэсэн чанартай, ёс зүйтэй бүтээлүүд гаргах гишүүдийнхээ санаачилгыг урамшуулан дэмжиж ажиллана. Бид энэхүү зорилгодоо хүрэхийн тулд:

- ✓ Нэгдэлдээ шинэ гишүүн хүлээж авахдаа үргэлж нээлттэй, баяртай байна;
- ✓ Бие биеийнхээ, мөн олон улсын сайн туршлагаас байнга суралцаж, хөгжиж байна;
- ✓ Жендэрийн мэргэжилтнүүд, эрдэмтэн судлаачдыг үйл ажиллагаандаа урин оролцуулж, мэргэжлийн байр суурь, дата судалгааг өндөрт тавин судалж байна;
- ✓ Улс төрч эмэгтэйчүүдтэй шударга, мэргэжлийн байр сууринаас харьцаж байна.



БИДНИЙ ҮНЭТ ЗҮЙЛ


Олон ургальч байдал: Нийгмийн янз бүрийн төлөөллийн дуу хоолойг уншигч, үзэгч, сонсогчдоо хүргэх нь олон ургалч үзлийг түгээх чөлөөт хэвлэлийн үүрэг гэдэгт бид итгэдэг. Эмэгтэйчүүдийн төлөөлөл шийдвэр гаргах түвшинд төдийгүй сэтгүүл зүйн агуулгад цөөн байгаа учраас бид мэдээ, сурвалжилга, ярилцлага хийхдээ эх сурвалжийн хүйсийн тэнцвэртэй байдлыг хангахыг хичээнэ;

Мэргэжлийн ур чадвар, ёс зүй: Хэнийг ч ялгаварлан гадуурхалт болон хэвшмэл буруу ойлголтын золиос болгохгүй байх нь сэтгүүлчийн мэргэжлийн, ёс зүйн үүрэг хариуцлага билээ. Тиймээс сэтгүүл зүйн бүтээлээ цоо шинэ, чухал өнцгөөс, жендэрийн мэдрэмжтэйгээр гаргахыг чармайн ажиллана.

Тогтвортой хөгжил: Жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилтын хэрэгжилтийг хянах, олон нийтэд ойлгуулахад хэвлэл мэдээллийн салбар чухал үүрэгтэй гэж бид үздэг. Иймд, жендэрийн тэгш бус байдал, хүний эрхийн асуудлыг гүнзгийрүүлэн судалж, баримтад тулгуурласан даацтай бүтээл хийнэ.

“Мэдрэмжтэй мэдээлэл” нэгдлийг Хэвлэл мэдээллийн зөвлөл болон Анлимитэд медиа группийн хамтарсан консорциумаас БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг (КОЙКА), НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж байгаа “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслийн хүрээнд үүсгэн байгуулав.

Та “Мэдрэмжтэй мэдээлэл” Фэйсбүүк пэйж болон группээс нэгдлийн үйл ажиллагаа, шинэ боломжуудын талаарх мэдээллийг аваарай.





**Яагаад бидэнд
жендэрийн линз
хэрэгтэй вэ?**



1995

онд Бээжинд болсон Дэлхийн эмэгтэйчүүдийн асуудлаарх НҮБ-ын бага хурлын үеэр батлагдсан Бээжингийн Үйл ажиллагааны мөрийн

хөтөлбөрт мэдээллийн салбарыг тулгамдсан 12 салбарын нэг болгон онцолж, тус салбарт эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, хэвлэл мэдээллийн агуулга дахь жендэрийн тэгш байдлыг дэмжиж, хэвшмэл ойлголтуудыг халах гэсэн стратегийн хоёр зорилго тавьжээ. Үүнээс хойш жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйг хөгжүүлэх ажлууд олон улсын хэмжээнд хэрэгжсэн ч ахиц дэвшил чамлалтай байгаа юм.

Таван жил тутам нэг өдрийг сонгож мэдээний мониторинг хийдэг Дэлхийн хэвлэл мэдээллийн мониторингийн төслөөс эмэгтэйчүүдийн дуу хоолойг гаргах тал дээр хэвлэл мэдээллийн салбар хойш суусаар байгааг анхааруулдаг. 1995 онд энэхүү мониторингийг анх хийхэд мэдээний субъект буюу мэдээгээр гарсан хүмүүсийн ердөө 17 хувь нь л эмэгтэйчүүд байж. Үүнээс 25 жил өнгөрөхөд энэ үзүүлэлт олигтой нэмэгдээгүй, 25 хувьд л хүрчээ. Хэрвээ энэ чигээр ахиц удаан байвал жендэрийн тэгш байдлыг мэдээний агуулгад харахын тулд бид дор хаяж 67 жил хүлээх хэрэгтэй болно. Гэвч 2015 онд мэдээний нийт эх сурвалжийн 24 хувийг бүрдүүлж байсан үзүүлэлт 2020 онд 25 хувьд хүрч өсөхөд хүргэсэн шалтгаан хэвлэл мэдээллийн агуулгыг жендэрийн өнцгөөс авч үздэг судлаачдын хувьд “хонгилын үзүүрт цухуйх гэрэл” болж байгаа юм. Учир нь BBC, “Bloomberg”, “Financial Times”, “The New York Times”, “The Globe and Mail”, “Toronto Star” зэрэг олон улсын томоохон хэвлэл мэдээллийн байгууллага жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйг хөгжүүлж, ялангуяа эх сурвалжийн хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах тал дээр идэвх санаачилгатай ажиллаж, шинэ арга барил, аргачлал нэвтрүүлж, тэрийгээ бусадтай харамгүй хуваалцаж байна. Жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүй нь хэвлэл мэдээллийн салбарын шинэ чиг хандлага болж, сэтгүүлчид, редакцууд үүгээрээ өрсөлддөг болох цаг хаяанд иржээ. Энэ нь чанартай, ёс зүйтэй сэтгүүл зүйг хөгжүүлж, уншигч, үзэгч, сонсогчдынхоо итгэлийг хүлээхэд нэн чухал болохыг олон улсын томоохон хэвлэл мэдээллийн байгууллагууд хэдийнэ ойлгоод байна. Товчхондоо, жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүй гэдэг нь: -Чанартай, ёс зүйтэй сэтгүүл зүй;

-Уншигч, үзэгч, сонсогчдын итгэлийг олж авах боломж;
-Бизнесээ өргөжүүлэх гарц;
-Ардчиллыг бэхжүүлэхэд оруулж буй хувь нэмэр юм. Одоо энэ бүхнийг задалж харцгаая.



ЧАНАРТАЙ, ЁС ЗҮЙТЭЙ СЭТГҮҮЛ ЗҮЙ

Жендэрт суурилан ялгаварлан гадуурхахгүй байх нь сэтгүүлчдийн мэргэжлийн, ёс зүйн стандартын чухал шаардлага юм. Олон улсын сэтгүүлчдийн нэгдсэн холбоо 1954 онд л “Сэтгүүлчид ялгаварлан гадуурхалтыг дэвэргэх аюул байгааг мэдэж, арьс өнгө, хүйс, бэлгийн чиг баримжаа, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал үүсэл, бусад зүйлд суурилсан ялгаварлан гадуурхалтаас зайлсхийхийн тулд чадах бүхнээ хийнэ” гэж тусгасан байдаг.


Тэгвэл Монголын Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын гуравдугаарт “Хэнийг ч арьс өнгө, яс үндэс, гарал угсаа, хүйсийн байдал, нас, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэнд, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг, гэр бүлийн байдлаар нь ялгаварлан гадуурхалтын золиос болгохгүй” хэмээгээд 3.2-т “Хэвлэл мэдээллийнхэн нийгэмд оршиж байгаа хэвшмэл ойлголтуудыг улам дэвэргэхээс зайлсхийнэ” гэж заасан.

Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим нь 10 бүлэг 24 заалттай бөгөөд үүний нэлээд хэсэг нь сэтгүүл зүйн бүтээлд хүний эрхийг дээдлэх, хохирогчийг хамгаалах, хүүхдийн эрхийг зөрчихгүй байх, бусдыг ялгаварлан гадуурхахгүй, гутаан доромжлохгүй байх, хувийн нууцыг хүндэтгэх талаар тусгасан нь сэтгүүл зүйд жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрийн мэдрэмжтэй байдлыг бий болгох суурь зарчмууд болж байна. Гэвч энэ тал дээр алдаа дутагдал элбэг гардаг. Тухайлбал, Хэвлэл мэдээллийн зөвлөл 2015-2020 онд нийт 383 гомдол хүлээн авсны 33 орчим хувь нь ялгаварлан гадуурхалт, хэвшмэл ойлголтыг дэвэргэсэн, хохирогчийг

хамгаалаагүй, хувийн нууцад хүндэтгэлтэй хандаагүй, хүүхдийн эрхийг зөрчсөн хэмээх гомдлууд байсан .

Мөн дэлхийн хүн амын тэн хагасыг бүрдүүлж буй эмэгтэйчүүдийн дуу хоолойг хэвлэл мэдээллээр хангалттай илэрхийлж чадахгүй байна гэдэг нь сэтгүүл зүй үнэн бодит байдлыг тусгах, нийгмийн толь болох үүргээ биелүүлж чадахгүй байна гэсэн үг.

Сэтгүүл зүйн салбарынхны дунд жендэр гэдэг нь тусдаа сэдэв бөгөөд түүгээр дагнасан сэтгүүлчдэд л хамаатай, цаг үеийн мэдээ зэргийг хийхэд энэ талаарх боловсрол хэрэггүй гэсэн ойлголт нийтлэг байдаг. Гэтэл ямар ч асуудал, сэдэв байсан хамаагүй, түүнийг жендэрийн линзээр харж шинжих нь тухайн сэдвийг бүрэн бүтнээр нь мэдээлэхэд амин чухал. Мэдээг илүү тэнцвэртэй, олон талын оролцоог хангасан байлгахын тулд юу мэдээ болохыг шийдэхээс эхлээд хэрхэн түүнийг хийх хүртэлх бүхий л явцад жендэрийн мэдрэмжтэй байх хэрэгтэй. Энэ нь зөвхөн сурвалжлагчид төдийгүй редакторууд, зураг дүрсний мэргэжилтнүүд зэрэг мэдээ хийхэд оролцож байгаа хүн бүрд хамаатай.



УНШИГЧ, ҮЗЭГЧ, СОНСОГЧДЫН ИТГЭЛИЙГ ОЛЖ АВАХ БОЛОМЖ

“Edelman” судалгааны байгууллагаас гаргадаг Итгэлийн барометрын үр дүн дэлхий даяар олон нийтийн хэвлэл мэдээлэлд итгэх итгэл туйлдаа хүртэл унасныг харуулдаг. Тиймээс уншигч, үзэгч, сонсогчдынхоо итгэлийг олж авах нь сэтгүүл зүйн тулгамдсан асуудал болоод байна. Өсөн нэмэгдэж буй худал, ташаа мэдээлэл, хараат бус хэвлэл мэдээллийн хумигдаж буй орон зай үүний нэг шалтгаан. Мөн олон янз байдал, төлөөллийг багтааж чадахгүй байгаа нь чухал шалтгаан гэж судлаачид үзэж байна. Дэлхий даяар сэтгүүл зүйн байгууллагууд эмэгтэйчүүд болон цөөнхийн

дуу хоолойг гаргах тал дээр учир дутагдалтай ажилладаг. Энэ нь нийгмийн маш олон бүлгүүд өөрсдийн төлөөлөл болох хүмүүсийг хэвлэл мэдээллээс олж харахгүй, улмаар сэтгүүл зүйд итгэхгүй, оролцохгүй байхад хүргэж байгаа юм. Тиймээс ч “Edelman”-ы ерөнхийлөгч Эд Уиллиамс “Төлөөллийг оруулж чадахгүй бол итгэлийг олж чадахгүй” гэж хэлсэн байдаг.

Оролцоо ба итгэлийн уялдаа холбоог харуулах судалгаа нэмэгдсээр байна. Иргэдийн дуу хоолойг хүргэж, олон янзын эх сурвалжаас мэдээлэл авах нь итгэл төрүүлэхүйц сэтгүүл зүйн бүтээл хийхэд чухал ач холбогдолтойг “Internews” сануулдаг. Хэвлэл мэдээлэлд итгэх итгэл буурч байгаа нь зөвхөн редакцуудын хувьд тулгамдсан асуудал биш юм. Иргэдийн мэдэх эрхийг хангах гэдэг утгаараа энэ нь нийгмийн, ардчиллын хувьд томоохон асуудал болж байна.

Ёс зүйн зарчмуудаа баримтлах, жендэрийн мэдрэмжтэй байх тал дээр өөрийн зохицуулалтаа сайжруулах нь сэтгүүл зүйн бүтээлүүдийн чанарыг сайжруулж, эцсийн дүнд олон нийтийн эрх ашгийг хамгаалах, уншигч, үзэгч, сонсогчдынхоо итгэлийг хүлээхэд зайлшгүй шаардлагатай. Мөн жендэрийн мэдрэмжтэй байх нь сэтгүүлч, редакторууд сэтгүүл зүйн бүтээлээ илүү чухал, сонирхолтой өнцгөөс гаргахад тус болно. Өөрөөр хэлбэл, жендэрийн мэдрэмжтэй ажилласнаар зөвхөн ёс зүйн зарчмаа баримтлаад зогсохгүй бусдаас ялгарч, шилдэг бүтээл хийхэд тустай.



БИЗНЕСЭЭ ӨРГӨЖҮҮЛЭХ ГАРЦ

Олон улсын томоохон хэвлэл мэдээллийн байгууллагын менежерүүд агуулгадаа жендэрийн тэгш байдлыг хангах нь сэтгүүл зүйн бүтээлийг чанартай болгож, итгэлийг олж авахад сайнаар нөлөөлөхөөс гадна санхүүгийн боломж нээж өгдгийг олж хараад байна. Эмэгтэйчүүдийн дуу

хоолойг нэмэгдүүлснээр редакц уншигч, үзэгч, сонсогчдын оролцоог дээшлүүлж, захиалагчдын тоог ихэсгэж, рекламн үнэ цэнийг ч өсгөж байгааг тэдний туршлага харуулж байна.

"Harvard Business Review" сэтгүүлд 2009 онд гарсан судалгаа дэлхий даяар хэрэглэгчдийн худалдан авалтын 80 хувийг эмэгтэйчүүд удирдаж байгааг харуулсан. Тиймээс реклам олгогчид агуулгадаа жендэрийн тэгш эрхийг чухалчилж үздэг болж буй. АНУ-ын Үндэсний зар сурталчилгаа эрхлэгчдийн холбооноос Жендэрийн тэгш байдлын хэмжилт хийдэг бөгөөд жендэрийн тэгш байдлыг зар сурталчилгаанд тусгах нь худалдан авалтыг нэмэгдүүлж, брэндийн нэр хүндэд сайнаар нөлөөллийг баталжээ.

АНУ, Их Британийн гурван эмэгтэй тутмын нэг нь эмэгтэй дүрийг хэвшмэл ойлголтын дагуу дүрсэлсэн кино, телевизийн шоу нэвтрүүлэг үзэхээ больсныг "Geena Davis Institute"-ийн хийсэн судалгаа харуулсан байна. Жендэрийн тэгш байдлыг тусгасан кинонууд илүү их ашиг олж эхэлсэн. Нэг л мэдэхэд Диснейн гүнжүүд цагаан морь унасан ханхүү ирж аврахыг хүлээж суух биш, өөрсдөө морио унаад хаант улсаа авардаг баатрууд болж хувирсан байгаа биз?

Дэлхий даяар газар авч байгаа энэхүү өөрчлөлтийг сэтгүүл зүйн байгууллагууд одоо л нэг юм олж харж, жендэрийн мэдрэмжтэй байх тал дээр ажиллаж эхлээд байна. Сэтгүүл зүйн бүтээлийг жендэрийн тэгш байдлыг хангах байдлаар хийснээр хэрэглэгчдийн тоо нэмэгдэж байгааг "Media Impact Project" төслийн судалгаа харуулжээ. Жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйн бүтээл хийхэд тэргүүн ач холбогдол өгч эхэлсэн BBC, "South China Morning Post", "Financial Times", "Bloomberg", Норвегийн "Amedia" зэрэг байгууллага үзэгч, уншигчдынхаа дунд судалгаа хийж үзэхэд эмэгтэйчүүдийн дуу хоолой, байр суурийг сэтгүүл зүйн бүтээлдээ элбэг оруулснаар хэрэглэгчдийн тоо нь өсөж, бизнест нь сайнаар нөлөөлж байгааг баталжээ.

АРДЧИЛЛЫГ БЭХЖҮҮЛЭХЭД ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР

Улс төр бол хэвлэл мэдээллийн бүтээлийн агуулгад асар том орон зай бий болгодог чухал салбар. Тиймээс ч радио, телевизийн мэдээний хөтөлбөрийн, өдөр тутмын сонинуудын, цахим мэдээллийн сайтуудын хамгийн эхэнд, тэргүүн нүүрэнд, онцлох

нүүр хуудсанд улс төрийн мэдээлэл давамгайлсан байдаг.

Улс төрийн мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй байлгахын тулд сэтгүүлч өөрөөсөө "Энэ бүхэн миний үзэгч, уншигч, сонсогчдоо ямар нөлөө үзүүлэх вэ?" гэж асуух нь чухал. Бүх шатанд гарч буй шийдвэрүүд энгийн иргэдэд хэрхэн нөлөөлж байна вэ? Хэвлэл мэдээлэл энэ шийдвэрийн үр дагаврыг хүртэж байгаа иргэд болон аливаа асуудалд хараат бус, мэргэжлийн байр суурь илэрхийлэх шинжээчдийн дуу хоолойг хангалттай гаргаж, мэдээллийг тэнцвэртэй дамжуулж чадаж байна уу?

Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс 2021 онд хийсэн мониторингийн судалгаанаас үзэхэд өдөр тутмын сонин, сайтуудын улс төрийн мэдээллийн нийт эх сурвалжийн 97/99 хувийг дан ганц сонирхлын бүлгийн эх сурвалж эзэлж байна.

Хэвлэл мэдээллийн туйлын зорилго бол улс төрчид, төрийн өндөр албан тушаалтнуудын үзэл бодол, байр суурийг хүргэх, тэдний дуу хоолой болох бус, харин улс төрийн бодлого, шийдвэр энгийн иргэдэд хэрхэн нөлөөлж буйг ойлгуулах юм. Хэрэв хэвлэл мэдээлэл энэ үүргээ биелүүлж үзэгч, уншигч, сонсогчдоо үнэн зөв, тэнцвэртэй мэдээллийг өгч чадвал өөрсдийг нь хамгийн сайнаар төлөөлөх хүнээ сонгож, бодлого, үйл ажиллагаанд нь хяналт тавих боломжийг иргэдэд олгож байна гэсэн үг.

Ардчилсан нийгэмд жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүй нь маш чухал хувь нэмэр оруулах бөгөөд олон нийтэд үнэн зөв мэдээлэл хүргэн тэдний мэдэх эрхийг хангаж улмаар зөв шийдвэр гаргахад тусалдаг. Мөн тэнцвэртэй, ёс зүйтэй мэдээллийг олон нийтэд хүргэсний үндсэн дээр иргэдийн нийгэм, эдийн засаг, улс төрийн оролцоог идэвхжүүлэх, бэхжүүлэх боломжтой.

Үүний зэрэгцээ хэвлэл мэдээллийн салбарыг дөрөв дэх засаглал гэж ярьдаг. Олон нийтийн эрх ашгийг хамгаалах "хоточ нохой"-н үүрэг гүйцэтгэдэг ч гэж тайлбарладаг. Энэ нь хүн амын олон талт бүлгүүдийн хэрэгцээ шаардлага, тулгамдсан асуудлыг тусгаж, тэдгээрийг шийдвэрлэх тал дээр шийдвэр гаргагчдаас хариуцлага нэхэх үүрэг хариуцлагыг хэлж буй хэрэг. Иймд, нийгмийн олон янзын төлөөллийн тулгамдсан асуудал, ашиг сонирхол, үзэл бодол, байр суурийг иргэдэд хүргэх нь асар чухал.



ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИН ДЭХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦОО ТУЛГАМДСАН АСУУДАЛ БОЛОХ НЬ



Монгол Улсын Үндсэн хуулийн 16.11-т улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй гэж заасан байдаг. Мөн манай улс 1946 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1954 оны Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн конвенц, 1981 оны Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцид нэгдэж, эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засаг, улс төрийн эрхийг хамгаалах амлалт өгсөн. Энэ бүх үүрэг амлалтыг биелүүлэхэд хэвлэл мэдээллийн салбар нэн чухал үүрэг гүйцэтгэх шаардлагатай.

Эмэгтэйчүүдийн улс төрийн эрх мэдэл сул байгааг харуулах найман баримт

1.

Дэлхийн дөрвөн парламентын гишүүн тутмын нэг нь эмэгтэй

Олон улсын парламентын холбооноос гаргадаг мэдээллээс үзэхэд дэлхийн хэмжээнд дөрвөн парламентын гишүүн тутмын нэг нь л эмэгтэй байна. Улс орнуудын үндэсний парламентууд дахь эмэгтэй гишүүдийн дэлхийн дундаж хувь 1995 онд 11.3 хувь байснаас өдгөө 25 хувь болж нэмэгджээ. Гэвч өөрчлөлт энэ хурдаараа удаан явах юм бол улс төр дэх жендэрийн ялгаа энэ зуунд арилахгүйг Дэлхийн эдийн засгийн форумын тооцоо харуулж байна. Үүний зэрэгцээ, НҮБ-ын гишүүн 193 орноос ердөө 15 улсын төр, засгийн тэргүүнээр эмэгтэй хүн сонгогдон ажиллаж байгаа юм.⁵

2.

Монгол бол эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийг баталгаажуулсан Азийн анхны улс

Монгол орон 1924 оны анхдугаар Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлд эмэгтэй, эрэгтэй хүний тэгш эрхийг хуульчлан тунхагласан Азийн анхны улс болсон. Мөн хуулийн 34 дүгээр зүйлд монгол эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн сонгох, сонгогдох эрхийг хуульчилсан байна. Социализмын бүтээн байгуулалтад эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй тэгш оролцож, шийдвэр гаргахад хувь нэмрээ оруулахын зэрэгцээ уламжлалт гэрийн хөдөлмөр эрхлэх, дунджаар таваас доошгүй хүүхэд төрүүлж, өсгөх, хүмүүжүүлэх давхар ачаа үүрэх болсныг

“Монгол эмэгтэйчүүд ойкосын хүрээнээс полисын тавцанд гарсан нь” нийтлэлд тэмдэглэжээ. Социализмын үед тогтоож өгсөн квотын үр дүнд хууль тогтоох байгууллагын төлөөллийн 23-25 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байсан бол 1990 оноос хойш энэ үзүүлэлт огцом буурсан.

3.

Хүн амын 51 хувийг бүрдүүлж буй эмэгтэйчүүдийн төлөөлөл улс төрд бага байна

Ардчилсан нийгэмд иргэдийн улс төрийн оролцоо, тэр дундаа нийгмийн олон талт бүлгүүдийн идэвхтэй оролцоог хангах нь туйлын чухал. Монгол Улс 1990 оноос хойш УИХ-ын сонгуулийг найман удаа, орон нутгийн сонгуулийг долоон удаа зохион байгуулсан. Сонгуулиар дамжуулж иргэд төрийн эрх барих эрхээ эдэлдэг боловч сонгогчдын 51 хувийг бүрдүүлж буй эмэгтэй хүйсийн төлөөлөл УИХ-д бага байна. Мөн 1993 оноос хойш болсон Монгол Улсын Ерөнхийлөгчийн 8 удаагийн сонгуульд нийт 22 хүн нэр дэвшсэнээс нэг нь л эмэгтэй байв.

4.

20 хувийн квот үр дүнгээ өгсөн ч эдүгээ “босго” биш “тааз” гэж ойлгогддог болжээ

2005 онд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 28.2-т нам эвслээс нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь нь

эмэгтэй байх заалт байв. Гэвч энэ заалтыг огт хэрэгжүүлэхгүйгээр 2007 онд УИХ-аас цуцалсан. Тэгвэл 2011 онд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 27.2-т сонгуульд оролцож байгаа нам, эвслээс нэр дэвшигчдийн 20-иос доошгүй хувь нь эмэгтэйчүүдийн төлөөлөл байна гэж заажээ. Энэхүү шаардлагыг хангаагүй нам, эвслийн нэр дэвшигчдийг сонгууль зохион байгуулж байгаа байгууллага бүртгэж авахгүй байхаар хуульчилсан нь уг заалтыг хэрэгжүүлэх хөшүүрэг болов. Квотын үр дүнд 2008 онд УИХ-д гурван эмэгтэй гишүүн байсан нь 2012 онд 11, 2016 онд 13 болж нэмэгдсэн ч 2020 онд өссөн үзүүлэлт гарсангүй. Эдүгээ 20 хувийн квотыг “босго” биш “тааз” гэж ойлгож эхэлсэн учраас квотыг өсгөх шаардлагатайг судалгаа харуулжээ.⁸



5. Монгол Улс Парламент дахь эмэгтэйчүүдийн жагсаалтаар сүүл мушгидаг

Олон улсын парламентын холбооноос сар бүр шинэчлэн гаргадаг Парламент дахь эмэгтэйчүүдийн жагсаалтаас үзэхэд Монгол Улс 185 орноос 135 дугаарт эрэмбэлэгдэж байна. Монголын парламентын гишүүдийн 17.1 хувийг эмэгтэй гишүүд бүрдүүлж байгаа бол Азийн дундаж 20 хувь, дэлхийн дундаж 25 хувиас дээш байгаа юм. Мөн Монгол Улсын түүхэнд одоогоор УИХ-ын дарга нэг ч эмэгтэй байгаагүйг энд дурдах нь зүйтэй.

6. Нийслэл, аймгийн засаг дарга нар дунд эмэгтэйчүүдийн төлөөлөл алга




2020 оны сонгуулийн үр дүнгээс үзэхэд аймаг, нийслэлийн ИТХ-ын төлөөлөгчдийн 16 хувь, дарга нарын есөн хувь, сум, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдийн 28 хувь, дарга нарын 15 хувь эмэгтэй байна. Дүүргийн засаг дарга нарын 22 хувь нь эмэгтэй байгаа бол нийслэл, аймгийн засаг дарга нар дунд хүн амын тэн хагасыг бүрдүүлж буй эмэгтэйчүүдийн төлөөлөл алга байна.

7. Монгол Улсад нэг ч эмэгтэй Ерөнхий сайд байгаагүй

Засгийн газрын хэмжээнд сайд нарын 28.5 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлэх болсон нь өмнөх жилүүдтэй харьцуулахад дэвшилтэй үзүүлэлт. Гэвч Монгол Улсын түүхэнд 33 Ерөнхий сайд байсан нь бүгд эрэгтэйчүүд юм¹⁰

8. Эмэгтэйчүүдийн улс төрийн эрх мэдлийг харуулах үзүүлэлтээр 156 орноос 116-дугаарт жагсаж байна

Дэлхийн эдийн засгийн форумаас жил бүр гаргадаг Дэлхийн жендерийн зөрүүтэй байдлын индекс нь эдийн засгийн оролцоо, боловсрол эзэмших байдал, эрүүл мэнд, улс төрийн эрх мэдэл гэсэн дөрвөн үзүүлэлтээр жендерийн зөрүүтэй байдлыг 0-1-ийн хооронд хэмждэг бөгөөд 1 гэдэг нь жендерийн тэгш байдалд бүрэн хүрснийг илэрхийлдэг. Исланд, Финланд, Норвеги, Шинэ Зеланд, Швед улс жендерийн эрх тэгш байдлыг хамгийн сайн хангасан учраас жагсаалтыг тэргүүлж байна. Харин Монгол Улс эрүүл мэнд, боловсролоор маш сайн үзүүлэлттэй байгаа боловч 146 орноос 70-дугаарт эрэмбэлэгджээ. Энэ нь эмэгтэйчүүдийн улс төрийн эрх мэдлийн түвшин хангалтгүй, авах ёстой 1 онооноос ердөө 0.121-ийг авч, 146 орноос 113 дугаарт жагссантай холбоотой



7 Цогц хөгжлийн үндэсний төв. (2021). Улс төр дэх залуучууд болон эмэгтэйчүүдэд тулгамдаж буй сорилт бэрхшээл.
 8 Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн. (2021). SheVotes Mongolia: Эмэгтэйчүүд, залуучуудын улс төрийн оролцоонд тулгарч буй саад бэрхшээлүүд
 9 <https://data.ipu.org/women-ranking?month=7&year=2022>
 10 Тоон мэдээллийг Эмэгтэйчүүдийн манлайллын сүлжээний илтгэлээс авав.
 11 <https://www.weforum.org/reports/global-gender-gap-report-2022/in-full>

Шинэ дуу хоолой: Эх сурвалжийн хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах нь



▶ Хүн төрөлхтний тэн хагасыг эмэгтэйчүүд бүрдүүлдэг атал хэвлэл мэдээлэл тэдний дуу хоолойг олон нийтэд хүргэх тал дээр учир дутагдалтай ажилласаар байна. Энэ нь сэтгүүл зүйн тэнцвэртэй байх, эх сурвалжаа ялгаварлан гадуурхахгүй, ижил тэгш, шударга хандах суурь зарчимтай тэрсэлдэж буй үзэгдэл юм.



Хэвлэл мэдээлэл эмэгтэйчүүдийг үл тоомсорлож байгааг харуулах зургаан баримт

1.

Дэлхий даяар дөрвөн эх сурвалж тутмын ганц нь л эмэгтэй байна

Дэлхийн хэвлэл мэдээллийн мониторингийн судалгааг 1995 онд анх хийхэд мэдээний субъект буюу мэдээгээр гарсан хүмүүсийн ердөө 17 хувь нь эмэгтэйчүүд байж. Үүнээс 25 жил өнгөрөхөд энэ үзүүлэлт 25 хувьд хүрчээ. Мөн мэдээ мэдээллийг сэдвээр нь ангилж үзвэл шинжлэх ухаан, эрүүл мэнд, нийгэм, эрх зүйн сэдвээр эх сурвалжуудын 30 хувь нь эмэгтэйчүүд байгаа бол улс төр, засгийн газартай холбоотой сэдвээр ердөө 20 хувьтай байна. Эмэгтэйчүүдийг элбэг гаргадаг шинжлэх ухаан, эрүүл мэндийн сэдэв нь мэдээний нийт агуулгын ердөө найман хувийг эзэлдэг бол цөөн эш татдаг улс төр, засгийн газрын талаарх мэдээлэл мэдээний хамгийн их буюу 25 хувийг эзэлдэг байна.

2.

Эмэгтэйчүүдийг ихэвчлэн гэрийн эзэгтэй, ээжийн үүргээр дүрсэлдэг

Мэдээний агуулга дахь эх сурвалжуудын 25 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байгааг задалж үзвэл гэрийн ажил болон эцэг эхийн үүргээр гарсан мэдээний эх сурвалжуудын 68 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байгаа юм. Тэгвэл улс төрийн мэдээний эх сурвалжуудын 18 хувийг л эмэгтэйчүүд бий болгож байгааг Дэлхийн хэвлэл мэдээллийн мониторингийн төслийн үр дүн харуулдаг.



68%



Гэрийн ажил, эцэг эх (өөр ажил дурдаагүй)

47%



Эрүүл мэнд, халамж, хүүхэд асаргааны ажил

35%



Активист, ИНБ, ТББ, үйлдвэрчний эвлэл

22%



Төрийн албан хаагч

18%




Засгийн газар, улстөрч, сайд, хэвлэлийн төлөөлөгч


3.

Монголд арван эх сурвалж тутмын нэг нь эмэгтэй байна

Монгол Улсын хувьд Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс 2021 онд хийсэн судалгаагаар өдөр тутмын сонины улс төрийн мэдээллийн эх сурвалжийн 14 хувь, мэдээллийн сайтуудын эх сурвалжийн 9.5 хувь л эмэгтэйчүүд байна. Мөн өдөр тутмын сонины хувьд Топ 20 эх сурвалжийн давтамж нийт аман эх сурвалжийн 52 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл, өдөр тутмын сонины хоёр аман эх сурвалжийн нэг



нь нэр бүхий 20 улс төрч байгаагийн хоёр нь л эмэгтэй байв. Тэгвэл мэдээллийн сайтуудын хувьд Топ 30 эх сурвалжийн давтамж нийт эх сурвалжийн 74 хувийг эзэлж байгаагийн дунд гурван эмэгтэй улс төрч багтжээ.



4. Үр дагавар хүртэгсэд болон мэргэжлийн бүлгийн эх сурвалж алга байна

Эх сурвалжийн түвшингээр ангилж үзвэл өдөр тутмын сонин/мэдээллийн сайтын улс төрийн мэдээллийн нийт эх сурвалжийн 97/99 хувийг сонирхлын бүлгийн эх сурвалж бүрдүүлж байгаа бол үр дагавар хүртэгсэд, мэргэжлийн бүлгийн эх сурвалж байхгүйтэй ижил байгааг Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс хийсэн судалгаа харуулсан. Иймд, улс төрийн мэдээллийг тэнцвэртэй, олон талын байр суурийг илэрхийлсэн байлгахын тулд улс төрч эмэгтэйчүүдийг элбэг эш татахаас гадна үр дагавар хүртэгсэд болон мэргэжлийн бүлгийн эх сурвалжаар эмэгтэйчүүдийг оролцуулахад анхаарах шаардлагатай байгаа юм.

5. Сонгуулийн үеэр телевизүүд эрэгтэй нэр дэвшигчдийг илүүтэй гаргажээ

“Глоб Интернэшнл Төв” ТББ-аас 2020 оны сонгуулийн үеэр хийсэн телевизийн мониторингийн судалгааны үр дүнгээс үзэхэд МҮОНТ-ээр гаргасан нэр дэвшигчтэй шууд холбоотой мэдээллийн 81 хувь нь эрэгтэй, 19 хувь нь эмэгтэйчүүдэд оногджээ. Арилжааны телевизүүдээс хүйсийн хувьд хамгийн их ялгаатай цаг оноосон нь TV9 телевиз байв. Тус телевиз эрэгтэй нэр дэвшигчдэд 90 хувь, эмэгтэй нэр дэвшигчдэд 10 хувийн цаг гаргасан аж.

6. Эмэгтэй улс төрчдийн эсрэг үзэн ядах үг хэллэг элбэг гардаг

“Цахим хэвлэл мэдээлэл дэх үзэн ядах үг хэллэг: Контент анализын судалгаа”-наас үзэхэд мэдээллийн сайтуудад эмэгтэй улс төрчдийн эсрэг доромжилсон агуулгатай, дооглосон, тохуурхсан, гутаасан өнгө аястай, бүдүүлэг үг хэллэг ашигласан сэтгүүл зүйн контентууд бүртгэгджээ. Судалгаанаас үзэхэд үзэн ядах үг хэллэгийн 30 хувийг сэтгүүлчид бүтээлдээ бичсэн бол 70 хувийг уншигчид сэтгэгдлийн хэсэгт үлдээсэн байна.



ЭХ СУРВАЛЖИЙН ГУРВАН ТҮВШИН

Аман эх сурвалжийг үндсэн гурван бүлэгт хувааж үздэг бөгөөд үйл явдал, нөхцөл байдлын талаар аль болох бодитой мэдээлэхийн тулд эдгээр гурван түвшний эх сурвалжаас мэдээлэл авах нь чухал. Үүнд:

1. Мэргэжлийн бүлэг: Тухайн үйл явдалтай шууд холбогдож, оролцоогүй боловч асуудалд шинжлэх ухааны үүднээс, аль болох хөндлөнгөөс хандаж, үнэн зөв мэдээлэл өгөх чадвар, мэдлэгтэй эх сурвалж. Уг асуудлыг сайн мэддэг, түүхэн байдал, хэтийн төлөвийн талаар бодитой зүйл хэлж чадах хүмүүс мэргэжлийн бүлэгт багтдаг.

2. Сонирхлын бүлэг: Тухайн асуудалд шууд хамааралтай, ихэнхдээ үйл явдлыг зохион байгуулсан хүмүүс энэ түвшинд багтана. Эрх мэдэл бүхий хүмүүс, голдуу улс төрчид, албан тушаалтнууд, төрийн бус байгууллага болон хувийн хэвшлийн төлөөллүүд орж болно. Энэ түвшний эх сурвалж асуудлыг илэрхий тодорхойлж, олон баримт өгч чадна. Тэдний хувьд үзэл бодлоо хүчтэй илэрхийлэх сонирхол нь давамгайлсан байдаг бөгөөд сэдвийг өөрийн эрх ашигт нийцүүлэн тайлбарлах эрмэлзэлтэй байдаг.

3. Үр дагавар хүртэгсэд: Үйл явдал, нөхцөл байдлын үр дагаврыг амссан, тухайн үйл явдалд шууд оролцсон хүмүүс. Тэдэнд дээрх үйл явц эерэг болон сөрөг (хохирсон, гэмтсэн) ямар нэг байдлаар нөлөөлсөн байдаг. Тухайн асуудал цаашид улам гүнзгийрэх тусам эдгээр хүмүүс гарах үр дагавар, түүний хүчтэй нөлөөнд өртөж байдаг. Тэд сэдвийг хүнд ойрхон, хүн төвтэй болгож, нийтлэлийг амьдруулдаг.

ТРЕНД: Олон улсын шилдэг туршлагауд

Бүтээж байгаа агуулгадаа эмэгтэйчүүдийн олон талт төлөөллийг эх сурвалж болгон оруулахын тулд редакц болон сэтгүүлчид ажиллаж байгаа арга барилаа өөрчлөх хэрэгтэй. Сүүлийн жилүүдэд олон улсын томоохон хэвлэл мэдээллийн байгууллагууд энэ ажлыг маш амжилттайгаар хэрэгжүүлж, бусад нь ч үлгэр дуурайл авах болсон. Үүнд:




ВВС-ийн Тэгш байдлын 50:50 төсөл

ВВС 2016-2020 оны “Олон янз байдал, оролцоог хангах стратеги” гаргахдаа хүний нөөц болон үйл ажиллагаагаа жендэрийн мэдрэмжтэй болгох, бүтээж байгаа агуулгаа төрөлжүүлэх, эх сурвалжид эзлэх эмэгтэйчүүдийн хувь хэмжээг 50 хувьд хүргэх зорилтуудыг тусгажээ.

ВВС-гийн Лондон дахь редакц мэдээн дэх эмэгтэйчүүдийн дуу хоолойг нэмэгдүүлэхийн тулд 2017 оноос эх сурвалжийн мониторинг хийж, богино хугацаанд өндөр амжилтад хүрээд байна. Тиймээс ВВС одоо энэ аргачлалаа ашиглан үндэстний цөөнх болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дуу хоолойг нэмэгдүүлэхээр ажиллаж эхэлжээ. Ташрамд дурдахад, ВВС онлайн хэрэгчлэгчдийнхээ дунд санал асуулга явуулахад олонх нь агуулга дахь эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдсэнийг анзаарсан гэж хариулсан бөгөөд 16-34 насны эмэгтэйчүүдийн ихэнх нь үүнээс болж илүү их контент хэрэглэж байгаа гэсэн аж.

Бүтээлийн агуулгадаа тэгш байдлыг хангах энэхүү аргачлалаа ВВС-гийн 50:50 төслийн баг олон улсын хэвлэл мэдээллийн болон бусад байгууллагатай харамгүй хуваалцаж буй. 2022 оноос Хэвлэл мэдээллийн зөвлөл тус төслийн албан ёсны түнш байгууллага болсон бөгөөд энэ боломж Монголын редакцуудад нээлттэй гэдгийг дуулгахад таатай байна. Тухайлбал, “Мэдрэмжтэй мэдээлье” редакцын менторшип хөтөлбөрийн хүрээнд “Зууны мэдээ” сонин, GoGo.mn мэдээллийн сайт 50:50 төслийн албан ёсны түнш болсон.



Bloomberg

“Bloomberg”-ийн “New Voices” санаачилга

“Bloomberg”-ийн “New Voices” санаачилга “Bloomberg” 2017 онд агуулгадаа судалгаа хийж үзэхэд редакцын зочноор ирж ярилцлага өгч байгаа шинжээч эх сурвалжуудын ердөө 10 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байжээ. Үүнийг өөрчилж, агуулга дахь эмэгтэйчүүдийн дуу хоолойг нэмэгдүүлэх зорилго тавин төлөвлөгөө гаргасан байна. 2018 оны эхээр “Bloomberg” өөрсдийн “New Voices” санаачилгаа олон нийтэд танилцуулсан. Энэ хүрээнд онлайн, хэвлэл, телевиз, радио, фото зураг, лайв үйл явдлууд зэрэг бүх платформынхоо агуулга дахь олон талт байдлыг хянаж, мониторинг хийж эхэлжээ. Мөн “Bloomberg” мэдээний программ хангамжаа шинэчилсэн бөгөөд эмэгтэйчүүдийг эш татсан мэдээ бүрийг бүртгэх боломжтой болгов.

Санаачилгыг эхлэх явцад эдийн засаг, бизнес, улс төр болон технологийн чиглэлээр ярих эмэгтэй шинжээч олдохгүй, олдлоо гэхэд зурагтаар гарахаас зайлсхийж, эмээж байжээ. Үүнийг шийдэхийн тулд “Bloomberg” сэтгүүлчид ашиглаж болох олон улсын дата бааз бүрдүүлсэн нь 500-гаас 5000 гаруй эмэгтэй эх сурвалжийн жагсаалт болж тэлжээ. Мөн хэвлэл мэдээлэлтэй харилцахаас эмээдэг эмэгтэйчүүдэд зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулсан байна. “Bloomberg” төдийгүй бусад хэвлэл мэдээллээр гарах эмэгтэй эх сурвалжийн тоог өсгөхийн тулд бизнес болон санхүүгийн салбарын өндөр албан тушаалтан эмэгтэйчүүдэд зориулсан дөрвөн цагийн сургалт хийж эхэлсэн. Гурван жилийн дотор 250 гаруй эмэгтэй тус сургалтад хамрагджээ. Энэ бүхний үр дүнд телевизийн шинжээч эх сурвалжуудын 10 хувийг бүрдүүлж байсан эмэгтэйчүүдийн тоон үзүүлэлтийг бараг гурав дахин нэмэгдүүлсэн байна.

13

Ирландын ТВ3 телевиз

Ганц нэвтрүүлэгчийн санаачилга улсынхаа салбарт эерэг нөлөө үзүүлсэн жишээ ч байна. Ирландын TV3 телевизийн улс төр, нийгэм эдийн засгийн цаг үеийн үйл явдлыг тоймлон хэлэлцдэг "Tonight with Vincent Browne" нэвтрүүлэг 2012 оноос хэлэлцүүлэгт оролцож байгаа экспертүүдийн тал нь эмэгтэйчүүд байх ёстой гэдгийг нэвтрүүлгийн бодлогодоо тусгажээ. Энэ нь ажлын өдөр бүрийн үдшийн 23:05-23:55 цагт гардаг, дунджаар 120,000 хүн үздэг нэвтрүүлэг юм.

Үүнийг хийхэд санхүү, тусгай хүн хүч, нөөц шаардлагагүй байснаараа онцлог. Жендэрийн тэгш бус байдлыг арилгая гэсэн бодлого, хүсэл эрмэлзэл, багаараа санал нийлж ажилласан нь л амжилтад хүргэжээ. Панелистаар оролцохоос эмээж, зайлсхийдэг эмэгтэй эдийн засагч, аналит, улс төрчидтэй цаг гарган ажиллаж, зурагтаар гарахад өөртөө итгэлтэй болоход нь тусалж байсан аж. Энэхүү сайн туршлагаас TV3 телевиз болон тус улсын бусад хэвлэл мэдээллийн байгууллага үлгэр дуурайл авчээ.



50:50 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү санаачилга нь бодит байдлыг шударгаар төлөөлөх сэтгүүл зүй, хэвлэл мэдээллийн контентыг байнга бий болгох тал дээр BBC төдийгүй дэлхий даяарх байгууллагуудад урам зориг өгөх, дэмжих зорилготой. Дөрвөн жилийн өмнө BBC-гийн Лондон дахь редакцаас эхэлсэн бөгөөд хэвлэл мэдээллийн хэрэгслээр гаргаж буй төлөөллийг үндсээр нь өөрчлөхийн тулд өгөгдөл, бүтээлч байдал, практикт суурилсан арга зүйг ашигладаг. Энэ нь BBC-ийн нэг мэдээний нэвтрүүлэг дэх эмэгтэйчүүдийн төлөөллийг хэмжих, нэмэгдүүлэх энгийн санаа байсан. Тэр цагаас хойш үүнийг BBC-гийн 750 хэлтэст, зөвхөн мэдээний бүтээгдэхүүнд төдийгүй бүх платформ дахь агуулгын багуудад нэвтрүүлсэн. Дэлхийн 30 орны 145 байгууллага BBC-тэй түншлэн энэхүү аргачлалыг ашиглаж байна. BBC энэхүү санаачилгынхаа хүрээнд дэлхийн өнцөг булан бүрд олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажилладаг. Мөн Их Британи дахь сэтгүүл зүйн сургуулиуд, салбарын байгууллагууд болон хэд хэдэн томоохон бизнесүүд нэгджээ. Энэ нь ажиллах хүчний жендэрийн асуудал бус агуулга дахь жендэрийн тэнцвэрт байдлыг хангахад чиглэсэн аргачлал юм.

Аргачлалыг хэрхэн хэрэгжүүлдэг вэ?

50:50 бол үйл ажиллагаанд нийцүүлсэн сайн дурын, өөрийгөө хянах систем юм. Энэ нь энгийн бөгөөд уян хатан, өөрчлөлтийг бий болгох гурван үндсэн зарчим дээр суурилсан аргачлал юм:

- Өгөгдөл цуглуулах;
- Юуг хянаж чадахаа хэмжих;



-Чанарыг нягт баримтлах.

Редакцууд өөрсдийн агуулгыг боловсруулж хянах явцдаа эх сурвалжийн хүйсээр ангилсан мэдээллийг цуглуулж, дараа нь BBC-ийн төв оффистой сар бүр хуваалцдаг. Ингэхдээ зөвхөн өөрсдийн хяналтад байдаг хувь нэмэр оруулагчдыг л тооцдог. Тухайлбал, мэдээний агуулгын хувьд тухайн мэдээний гол эзэн болсон хүнийг (сонирхлын бүлгийн эх сурвалжийг) бүртгэхгүй, харин сурвалжлагч сонгож болох бусад эх сурвалжийг бүртгэдэг байна. Ингээд мэдээг сурвалжлах сэтгүүлч, ашиглах кэйс судалгаа, ярилцлага авах шинжээчдийг бүгдийг бүртгэнэ. Төслийн багууд 1000 гаруй эмэгтэй эх сурвалжийн дотоод жагсаалттай болсон бөгөөд эмэгтэй эх сурвалжуудын хэвлэлээр гарах итгэлийг дэмжихийн тулд BBC-ийн студиуд Нээлттэй хаалганы өдөрлөг хийх болсон.

Үр дүн:

50:50 нь бодит бөгөөд тогтвортой өөрчлөлт бий болгох боломж олгодог. 2022 оны дөрөвдүгээр сард гаргасан жилийн тайлангаас харахад мэдээлэл ирүүлсэн багуудын 61 хувийн бүтээлд эх сурвалжийн 50-иас доошгүй хувийг эмэгтэйчүүд эзэлжээ. Үүнийг анх хийж байхад энэ үзүүлэлт 35 хувьтай байсан юм.

Дараагийн зорилго:

BBC цаашдаа илүү ахиц дэвшил гаргахыг зорьж байна. Тиймээс 50:50 аргачлалаа ашиглан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, үндэстний цөөнхийн төлөөллийг нэмэгдүүлэхээр ажиллаж эхэлсэн. 220 гаруй баг үүнд нэгдсэн бөгөөд өнгөрсөн аравдугаар сараас хойш ажиглахад тал хувь нь сайжирч байгааг харж болно. Мөн 2022 оноос мэдээлэл цуглуулах хүснэгтүүдийг 50:50 Tracker-аар солих шинэ аргыг нэвтрүүлнэ. Энэ нь нээлттэй эх сурвалж байх бөгөөд ашиглахад илүү хялбар, янз бүрийн төрлийн контент цуглуулахад тохируулж болох үнэ төлбөргүй хяналтын самбар юм.

Нэмэлт мэдээлэл:

<https://www.bbc.co.uk/5050>

<https://www.bbc.co.uk/5050/partners/home>

МИРАНДА ХОЛТ:

Монголын хэвлэл мэдээлэл бидэнд хандаж байгаад баяртай байна



Бид BBC-ийн 50:50 төслийн гадаад түнш эрхэлсэн ахлах мэргэжилтэн Миранда Холттой товч ярилцлага хийлээ. Тэрбээр өмнө нь Вестминстер дэх BBC-ийн улс төрийн шууд хөтөлбөрийн туслах редактораар ажиллаж, сонгуулийн мэтгэлцээний олон хөтөлбөрт продюсер хийж байсан. Миранда 50:50 төслийн үйл ажиллагаанд эхнээс нь оролцож, улс төрийн мэдээллийн шууд нэвтрүүлгүүдэд урих эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх тал дээр идэвх санаачилгатай зүтгэж иржээ.

Ингээд Мирандатай хийсэн ярилцлагыг хүргэе.

-50:50 төсөл амжилтад хүрсэн гол шалтгааныг та юу гэж хардаг вэ?

-Энэхүү аргачлалыг хэрэгжүүлэхэд хялбар, тэр л 50:50 төсөл амжилтад хүрсэн гол шалтгаан юм. Өөрчлөлт хийхийн тулд дата цуглуулах нь хамгийн чухал. Өдөр бүр, долоо хоног бүр, сар бүр дата цуглуулснаар та онлайн нийтлэлүүд, эсвэл телевиз, радиогийн нэвтрүүлгүүдээр хэр олон эмэгтэй орж байгааг хянаж чадна. Түүнчлэн бид зөвхөн удирдаж чадах зүйлээ л бүртгэж, тоолдог. Таны мэдэж байгаачлан нийгмийн ихэнх салбарт эрэгтэйчүүд ноёрхдог. Монголд гэхдээ боловсрол, ажлын байранд эмэгтэйчүүдийн төлөөлөл маш сайн байдгийг би мэдэж авсан. Гэхдээ тухайлбал улс төрийн салбарт, төрийн болон бизнесийн салбарт шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл бага байгаа болов уу. Энэ ч утгаараа



мэдээгээр гарах шаардлагатай эрэгтэй эх сурвалж байвал оруулж болно, харин түүнээс гадна хэнийг оруулах вэ гэдгээ бид шийддэг шүү дээ. Тэгэхээр бид өөрсдийн удирдаж чадах зүйл гэж юуг хэлээд байна вэ гэхээр нийтлэл, нэвтрүүлгээ хийхдээ хэнээс яриа авах, эш татахаа шийдэхдээ л эмэгтэй эх сурвалжуудыг давамгайлж оруулж ирэх, шинэ дуу хоолой эрж хайх болдог гэсэн үг.

-Үүнийг та өөрийн туршлага дээр үндэслэн тайлбарлаж өгөөч?

-Би өмнө нь BBC-ийн өдөртутмын улс төрийн хэлэлцүүлгийн шууд нэвтрүүлэгт ажилладаг байсан. Бид үйл явдлын дүрс авахдаа Ерөнхий сайд, Эдийн засгийн сайд, Эрүүл мэндийн сайд нарыг тухайлбал оруулдаг, тэд бүгд эрэгтэй. Тэд мэдээг бий болгож байгаа хүмүүс учраас бид тэднийг тоолдоггүй. Гэхдээ тухайн цаг үеийн үйл явдлын талаар сайн мэддэг, хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулж болох улс төрийн сонин тоймч, судлаач зэрэг өмнө нь телевизээр огт гарч байгаагүй эмэгтэйчүүдийг олж хэлэлцүүлэгтээ оруулж байсан. Тэдний зарим нь сайн, зарим нь бүр гайхалтай мундаг байсан учраас манай бусад нэвтрүүлэг, хөтөлбөрүүдэд ч урьж оруулж байв. Хэвлэл мэдээлэлтэй өмнө нь огт харьцаж байгаагүй

ee

Өөрчлөлт
хийхийн тулд
өдөр бүр дата
цуглуулах нь
хамгийн чухал.

dd

хүмүүст бага зэрэг зөвлөх, сургах шаардлага гардаг. Энэ бүхэн мэдээж ялимгүй цаг хугацаа шаардана. Гэхдээ та сэтгэлээсээ хандаж чадвал болно.

-Улс төрийн салбарт эмэгтэйчүүд цөөхөн байдаг учраас эх сурвалж олох нь амаргүй ажил. Та Монголын сэтгүүлчдэд юу гэж зөвлөх вэ?

-Нэг талаас эмэгтэй эх сурвалж олох нь амархан байж болно. BBC-д бидэнд холбоо барих эх сурвалжийн жагсаалт байдаг. Тухайлбал, би уур амьсгалын өөрчлөлт сэдвээр нэвтрүүлэг хийж байлаа гэж

бодоход энэ талаар академик түвшинд ярьж болох эмэгтэй эх сурвалжуудаа тэр жагсаалтаас хялбархан гаргаад авчих жишээтэй. Заримдаа энэ нь илүү цаг, судалгаа шаардсан ажил болох нь ч бий. Жишээ нь, та Монголд байгаа их дээд сургуулиуд, иргэний нийгмийн болон төрийн байгууллагууд, хувийн хэвшлийнхэн, холбоод зэргийн хэвлэл мэдээлэлтэй харилцах ажилтантай яриад, бидэнд ийм сэдвээр ярих эмэгтэй эх сурвалж хэрэгтэй байна гэж хандаж болно. Тухайн байгууллагын захирал нь эрэгтэй хүн байлаа гэхэд түүний дараа орох удирдах, ахлах түвшний, сэдвээ сайн мэддэг эмэгтэй байж л байдаг. Тухайн эмэгтэй өмнө нь хэвлэл мэдээлэлтэй огт харилцаж байгаагүй бол сургалт ч юм уу, өөртөө итгэлтэй байхад нь бага зэргийн тусламж дэмжлэг хэрэгтэй болно. BBC-д бид мөн улс төрийн намуудад хандаж манлайлан гарч ирж байгаа эмэгтэйчүүдийнх нь дуу хоолойг илүүтэй гаргах тал дээр анхаарсан. Эмэгтэй улс төрчдөд зориулсан нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах зэрэг ажлуудыг хийдэг

-Хэвлэл мэдээллээр өмнө нь гарч байгаагүй эмэгтэйчүүдээс ярилцлага, мэдээлэл авахын тулд нэлээд цаг, хөдөлмөр зарцуулдаг

юм шиг байна. Гэсэн ч BBC амжилтад хүрч, өөрчлөлт бий болгож чаджээ. Та бүхэн юунаас урам зориг авч ажилладаг вэ?

-50:50 төсөл бүх зүйлийг өөрчлөөд байгаа юм биш. Нийгэм өөрөө өөрчлөгдөж байгаа шүү дээ. Эмэгтэйчүүд илүү өндөр боловсролтой болж байна. Улс төр, бизнесийн шийдвэр гаргах түвшинд манлайлан гарч ирж байгаа эмэгтэйчүүд зөндөө байгаа. Тэднийг олж, гаргах нь л бидний хийж байгаа ажил. Энэ чинь нэг их бүтэхгүй, хэтэрхий холын, том зорилт биш. Бага зэрэг тууштай байдал л хэрэгтэй. Учир шалтгаан нь тодорхой. Манай хүн амын тэн хагас нь эмэгтэйчүүд. Бид тэр нийгмийнхээ тусгал болохыг л зорьсон гэсэн үг. Тэр тусмаа BBC Их Британийн олон нийтийн телевиз учраас хэрэглэгчдээсээ лицензийн төлбөр авдаг. Тиймээс тэр төлбөрөө төлж байгаа иргэд, нийгмээ бид заавал төлөөлөх ёстой.

Бид тав дахь жилдээ төслөө хэрэгжүүлээд явж байна. Хүүхдийн нэвтрүүлэг, улс төрийн хөтөлбөрүүд, баримтат нэвтрүүлгүүд, уран сайхны нэвтрүүлгүүд хүртэл бүгдээрээ энэ туршлагыг нэвтрүүлж ажилладаг болсон. Зөвхөн эмэгтэйчүүд төдийгүй эрэгтэйчүүд, хамт олноороо үүнийг хийж байгаа нь үнэхээр сайхан байдаг.

-BBC-ийн 50:50 төслийн түнш байгууллага болох зорилготой Монголын редакцуудад хандаж юу хэлэх вэ?

-Монголын хэвлэл мэдээлэл бидэнд хандаж байгаад бид туйлын баяртай байгаа. Хэрвээ та бидэнтэй түншлэн ажиллахыг хүсэж байвал бид таатай байх болно. Энэхүү аргачлалыг хэрхэн нэвтрүүлж, ашиглах нь уян хатан. Та бүхэн өөрсдөдөө зохицуулаад хийж болно. Үүнийг яг ингэж л хийнэ гэсэн хатуу шаардлага огт байхгүй. Гэхдээ бидэнд тодорхой зарчмууд бий, тэдгээрийг хэрхэн нэвтрүүлэх тал дээр тусалж дэмжээд явна. Эцсийн дүндээ энэ нь орчин үеийн нийгмийг төлөөлөх, эмэгтэйчүүдэд байх ёстой талбарыг нь гаргаж өгөх, мөн залуу үеийнхэнд шинэ дуу хоолойг эрж хайж, гаргах тал дээр идэвх санаачилгатай ажилладаг гэдгээ батлан харуулах тухай ойлголт юм. Байнга яриа авдаг эрэгтэй эх сурвалж руугаа ярих биш, тухайн сэдвийг сайн ярьж чадах эмэгтэйг эрж хайж олно л гэсэн үг. Тэгэхэд л өөрчлөлт бий болдог.

-Баярлалаа. ■



ЗӨВЛӨМЖ

Эх сурвалжийн хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах тал дээр редакцын хэрэгжүүлэх стратеги

Жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйг хэрэгжүүлж байгаа энэ мэт олон амжилттай туршлагыг судалсны үндсэн дээр редакц эх сурвалжийн хүйсийн тэнцвэртэй байдлыг хангахын тулд төлөвлөж судлах, бүртгэл хөтлөх, редакцын ажилтнуудын оролцоог хангах, эх сурвалжуудаа чадавхжуулах гэсэн дөрвөн стратегийн ангилал гарган хийж болох үйл ажиллагаануудыг “Бодит байдлыг тусга” гарын авлагад зөвлөсөн байдаг. Энэ хүрээнд юу хийж болох дэлгэрэнгүй зөвлөмжийг хүргэе

Төлөвлөж судлах:

Юуны түрүүнд редакцынхаа одоогийн бэлтгэж байгаа агуулга дахь эх сурвалжуудын хэчнээн хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байгааг тооцоолж гаргаарай. Үүнийг улс төр, эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд гэх мэт салбар бүрээр ангилж гаргах нь зүйтэй. Ингэснээр та бүхний бүтээж буй агуулга хэр жендэрийн тэнцвэртэй (эсвэл тийм биш) байгааг олж мэднэ. Мөн зарим сэдвээр, тухайлбал гэр бүл, жендэр сэдвээр эмэгтэй эх сурвалж давамгай, эрэгтэйчүүд ховор байх нь ч мөн жендэрийн тэнцвэр алдагдсаныг харуулна.

Мэдээн дэх эмэгтэйчүүдийн, эсвэл сэдвээсээ хамаараад эрэгтэйчүүдийн дуу хоолойг нэмэгдүүлэх тодорхой, хэмжиж болохуйц, хүрч болохуйц зорилго тавих. Тухайлбал, Монголд магистр, докторантурт суралцаж байгаа хүмүүсийн 60 гаруй хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байна. Тиймээс мэдээгээр гарч байгаа мэргэжилтнүүдийн багаар бодоход 50 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлэх нь зохистой. Мөн гэр бүл, жендэрийн сэдвээр аль болох эрэгтэй эх сурвалжийн тоог нэмэгдүүлэх зорилго тавьж болно.

Зорилгодоо хүрэх шаталсан төлөвлөгөө гаргаарай. Тухайлбал, эхний жилд улс төрийн сэдвээр ярих эмэгтэй эх сурвалжуудын эзлэх хувийг 40 хувьд, дараагийн жилд нь 50 хувьд хүргэх гэх мэтээр. Хамгийн гол нь хэмжиж болохуйц, дүгнэлт хийж, амжилтад хүрснээ тэмдэглэж болохуйц зорилтууд байх шаардлагатай.

Эх сурвалжийн хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоо нийтлэлийн бодлого, мэдээ, сурвалжилгад тавигдах шаардлагадаа тусгаж өгөх нь зүйтэй. Тухайлбал, BBC стратегийн зорилгодоо үүнийг тусгасан учраас л 50:50 санаачилга төрсөн байдаг.

Санаачилгадаа тохирсон, гоё нэр өгөх нь редакцын ажилтнууд төдийгүй бусад байгууллага, хамгийн гол нь танай уншигч үзэгчид ойлгож, дэмжихэд тусална. “Bloomberg” “Шинэ дуу хоолой”, BBC 50:50, “France 24” бол “51 хувь” гэх мэт нэрээр санаачилгадаа олны анхаарлыг татаж, уриалга ч гаргаж байсан. Тэгвэл Монголын CoGo.mn мэдээллийн сайт “Тэнцвэр” нэртэй санаачилга гаргаж, зарласан билээ.


Бүртгэл хөтлөх:



Агуулга дахь жендэрийн тэнцвэрт байдлыг хангахын тулд эх сурвалжуудаа хүйсээр ангилах мониторингийн арга хамгийн бодит үр дүн үзүүлж байгаа. BBC-ийн 50:50 төслийн мониторингийн аргачлалыг ашиглах боломжтой. Дэлхийн 30 улсын 140 гаруй байгууллага энэ хөтөлбөрийн түнш болж, уг аргачлалыг ашиглаж эх сурвалжуудаа төрөлжүүлж буй. Хэвлэл мэдээллийн зөвлөл 50:50 төслийн албан ёсны түнш байгууллага болсон бөгөөд Монголын редакцуудыг BBC-тэй холбож, уг аргачлалыг ашиглахад тусалж дэмжихэд нээлттэй байна.



Бүртгэл хөтлөхдөө эх сурвалжийн түвшинг бүү мартаарай. Тухайлбал, улс төрд өнөөгийн нөхцөлд эмэгтэйчүүд цөөн байгаа, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, УИХ-ын дарга гэх мэт гол эх сурвалжууд бүгд эрэгтэйчүүд байна. Тиймээс улс төрийн мэдээг илүү тэнцвэртэй байлгахын тулд сонирхлын бүлгийн эх сурвалж эрэгтэй байлаа гэхэд мэргэжлийн бүлгийн байр суурь илэрхийлэх эмэгтэй шинжээчийн яриаг оруулаад ирэхэд л болно. Бүртгэл хөтлөхдөө ашиглаж болох загвар хүснэгтийг Хэвлэл мэдээллийн зөвлөлд хандан авч ашиглана уу.



Редакцын ажилтнуудын оролцоог хангах:



Редакцын ажилтнууд бүгд оролцоход туслахын тулд санаачилгын хүрээнд редакцын уулзалтыг тогтмол давтамжтай зохион байгуулах хэрэгтэй. Багийн гаргаж байгаа амжилтыг тэмдэглэх, хүрэх зорилгоо сануулах, мөн ажилтнууд ямар бэрхшээлтэй тулгарч байгаа, ямар арга хэрэглэж байгаа, амжилтад хүрэхийн тулд ямар нөөц хэрэглэгдэхүүн хэрэгтэйг ярилцаж, туршлага судлах боломж бүрдүүлэх нь чухал. Редакцын хүн бүр, тэр дундаа эрэгтэйчүүдийг татаж оролцуулах хэрэгтэйг санаарай.

Эх сурвалжуудаа чадавхжуулах:



Төрийн байгууллагууд, мэргэжлийн холбоод зэргийн олон нийттэй харилцах мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж болно. Байнга яриа өгдөг эрэгтэй эх сурвалж биш, харин тухайн сэдэв, асуудлаа сайн мэдэх эмэгтэй эх сурвалжуудтай танилцуулахыг хүсээрэй.



Эх сурвалжийн жагсаалтаа байнга шинэчлэхийн тулд мэргэжлийн холбоодтой хамтран ажиллаж болно. Тэдэнд өөрсдийн санаачилга, зорилгоо танилцуулж, тухайн салбарт эмэгтэй эх сурвалжуудын дуу хоолой сул байдаг талаар мэдэж, гишүүддээ энэ талаар танилцуулахад нь туслаарай. Жишээ нь, “Bloomberg” эрчим хүчний салбар дахь эмэгтэй захирлуудын “Hawthorne Club” холбоотой, “Toronto Star” сонин эмэгтэй зохион бүтээгчид, бизнес эрхлэгчдийг дэмжих “She Innovates Alberta” байгууллагатай хамтарч ажилласан туршлага бий. BBC улс төрийн намуудад хандаж, улс төрийн байр сууриа илэрхийлэх эмэгтэй эх сурвалжуудтай холбож өгөхийг хүссэнээр амжилтад хүрсэн байдаг.



Сэтгүүлчид ашиглахад хялбар болгох үүднээс эмэгтэй эх сурвалжуудтай холбоо барих жагсаалт буюу дата сан гаргаж өгөөрэй. Энэ аргыг BBC, “Bloomberg” төдийгүй Скандинавын орнуудын редакцууд хэрэглэж үзэхэд өндөр үр дүн үзүүлсэн байдаг. Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс эмэгтэй эх сурвалжийн дата сан үүсгэх хакатон зохион байгуулж, 400 орчим эх сурвалжийн жагсаалт гаргасныг мөн авч болно.



Онлайн орчинд эх сурвалж болсон эмэгтэйчүүдийг сэтгэгдлээр гутаах, доромжлох тохиолдол түгээмэл байдаг. Тиймээс эмэгтэй эх сурвалж мэдээний сэтгэгдлийг хаалгах хүсэлт тавих тохиолдолд редакц уян хатан хандах, хүсэлтийг хүлээн авах зохицуулалт бий болгох хэрэгтэй.

Эмэгтэй мэргэжилтнүүд эх сурвалж болохоос татгалздаг есөн шалтгаан: Тэднийг хэрхэн татан оролцуулах вэ?



Канадад төвтэй “Informed Opinions” байгууллага сүүлийн 10 жилд 2500 эмэгтэйгээс судалгаа авч хэвлэл мэдээлэлтэй харилцах, ярилцлага өгөхөд ямар бэрхшээлтэй тулгардаг тухай лавлажээ. Уг судалгааны үр дүнгээс үзвэл эмэгтэй мэргэжилтнүүд эх сурвалж болохоос татгалзахад дараах есөн шалтгаан голчлон нөлөөлдөг байна:

1.

Тэр олны анхаарлын төвд орох дургүй

Эмэгтэйчүүд анхаарлын төвд орох бус нийгэмд өөрчлөлт бий болгоход илүү ач холбогдол өгөх хандлагатай байдаг. Тиймээс түүний үзэл бодол, дүн шинжилгээ нь уг мэдээнд ямар ач холбогдолтой, энэ асуудал хэчнээн хүний амьдралд нөлөө үзүүлж буйг тайлбарлахын зэрэгцээ нэг хүний дуу хоолой ч үнэ цэнтэй байдгийг сануулаарай.

2.

“Би шилдэг нь биш”

Туршлагатай, чадварлаг эмэгтэй мэргэжилтнүүд “Би шилдэг нь биш”, “Надаас өөр сайн хүнээс яриа ав”, “Би байнга л ярилцлага өгдөг” зэргээр өөрөөсөө бусдыг дэмжиж, урдаа оруулахыг илүүд үздэг. Энэ тохиолдолд “Шилдэг хүн” гэж цор ганц хүн байдаггүйг түүнд сануулж болно. Мөн олон нийтэд тус дэм болохуйц мэдээллийг тэр өгч чадна гэдгийг ойлгуулаарай.

3.

Хэвлэлээр эмэгтэйчүүдийн дуу хоолой бага гардгийг төдийлөн мэддэггүй

Эх сурвалж болохуйц эрэгтэй мэргэжилтэн олон байхад яагаад заавал эмэгтэй хүн сонгож байгааг тэр төдийлөн ойлгохгүй байж болно. Иймд та бэлтгэж буй мэдээгээрээ дамжуулан хэвшмэл ойлголтыг эвдэж, нийгмийн хүлээлтээс өөр дүр зургийг бий болгох, эмэгтэй мэргэжилтнүүдийн нэр хүндийг нэмэгдүүлэн, эх сурвалжийг тэнцвэртэй байлгахыг зорьж байгаагаа тайлбарлаарай.

4.

Цахим орчинд элдвээр хэлүүлэхээс айж байгаа

Ялангуяа улс төрийн сэдэвтэй мэдээгээр эмэгтэй эх сурвалж гарахад олон нийт шүүмжлэх, цахим орчинд элдэв янзаар гутаан доромжлох нь түгээмэл. Энэ тохиолдолд редакцын бодлого, эх сурвалжийг хамгаалах бодлогоо танилцуулаарай. Хүсвэл нэрээ нууцалж, зургаа тавихгүй байх боломжтойг сануулж, мэргэжлийн редакцын хувьд эх сурвалжаа нууцлах эрхтэй гэдгийг хэлээрэй.

5.

Тэр завгүй

Түүний цаг заванд тохирох уян хатан харилцааны аргуудаас санал болгоорой. Заавал уулзах бус утсаар, онлайнаар ярилцлагаа авах, өдрийн цайны цагаар уулзалтаа товлох, түүнтэй ойрхон орчинд ярилцах гэх мэт санал тавиарай.

6.

Тэр хэвлэл мэдээллээс айж байгаа

Зарим хүнд хэвлэлд ярилцлага өгөх нь сүрдмээр, аймаар зүйл мэт санагддаг. Нэг үг л буруу зөрүү хэлчихвэл харамсаж мэднэ гэж эмэгтэйчүүд айж магадгүй. Түүнд найрсаг хандаж, хэрхэн ажилладгаа танилцуулаарай. Хүсвэл яриагаа дахин бичүүлж, мэдээллээ урьдчилан бэлтгэж болно гэдгийг сануулаарай. Мэдээ, нийтлэлийг шууд яриа аваад л цацчихдаггүй, эх сурвалжаа хамгаалж, мэдээллээ боловсруулж, мэргэжлийн хүмүүстэй зөвлөлдөж, редактораар засуулсны эцэст нийтэлдэг тухай хэлж ойлгуулахад илүүдэхгүй. Хэрэв шаардлагатай бол нийтлэхээсээ өмнө өөрт нь харуулж, хянуулж болох тухай зөвлөлдөөрэй. **Эх**

7.

сурвалж болоход маш их бэлтгэл хэрэгтэй гэж боддог

Түүнээс хэр их мэдээлэл авах шаардлагатай байгаагаа барагцаалан хэлж өгөөрэй. Мэдээнд яриа өгөхөд 2-3 минут болно гэх зэргээр авах мэдээллийнхээ тухай баримжаа өгснөөр эх сурвалж мэдээллээ хялбархан бэлтгэж, айж сандрахаа ч болино.

8.

Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагад итгэх итгэл нь алдарсан

Сэтгүүлчид итгэж яриа өгтөл нэр устай нь зарласан, эх сурвалжаа хамгаалаагүй, хэлсэн үгийг нь урвуулан ашигласан, яриаг нь өөрчлөн цацсанаас болж хэвлэл мэдээлэлд итгэх итгэл нь алдарсан байж мэднэ. Түүний итгэлийг олж авахын тулд ажил хэрэгч хандаж редакцын бодлого, эх сурвалжаа хамгаалах бодлогоо танилцуулаарай.

9.

Тэр гадаад төрхөндөө санаа зовдог

Яриа өгч байгаа ямар ч хүн олон нийтийн мэдээллийн хэрэгслээр аятайхан харагдахыг хүсдэг. Тиймээс түүнд хэрэгтэй зүйлийг нь санал болгож, гадаад төрхөндөө анхаарах цаг гаргаж өгөөрэй. Телевизийн студид нүүр будалтын артист байгааг дуулгаж, өөртөө итгэлтэй харагдахад нь тус дэм болох боломжтой. Түүнд ямар хувцас өмсвөл тохиромжтой гэдгийг ч урьдчилан сануулж, зөвлөлдөөрэй.



Б.ХАЛИУН:

**Эх сурвалжийн дата
сан сэтгүүлчдэд
хэрэг болно гэдэгт
итгэлтэй байна**

“Nikkei Asia”, AFP болон бусад олон улсын хэвлэлд бүтээлээ гаргадаг, чөлөөт сэтгүүлч Б.Халиунтай ярилцлаа. Тэрбээр хүний эрхийн асуудлыг олон нийтэд хүргэхэд анхаарч ажилладаг, мөн “Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд” төрийн бус байгууллагад сайн дурын, жендэрийн тэгш эрхийн хөтөлбөрийн ажилтан хийж байсан туршлагатай. “Мэдрэмжтэй мэдээлье” нэгдлийг байгуулсан цагаас эхлэн зарим сургалт, хэлэлцүүлэг, үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байна.



Сэтгүүлчид
эмэгтэйчүүдийг
орхигдуулчихдаг нь
нийтлэлээ богино
хугацаанд гаргах ёстой
байдагтай холбоотой
болов уу.



**-“Мэдрэмжтэй мэдээль”
нэгдлийн үйл ажиллагаанаас олж
авсан хамгийн чухал зүйл нь юу
вэ?**

-Эх сурвалжийн хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах хэрэгтэйг маш сайн ойлгож авлаа. Хэвлэл мэдээллээр эмэгтэйчүүдийг бага гаргадаг гэсэн судалгааг танилцуулсны дараа энэ тал дээр анхаарч эхэлсэн. Жендэрийн чиглэлээр өмнө нь ажиллаж байсан, мэдлэг, мэдээлэл харьцангуй сайтай хэрнээ яг энийг анзаарч байгаагүй юм билээ. Ямар ч байсан зорилго тавиад, эх сурвалжийн хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах хэрэгтэйг сургалтын үеэр ойлгосон. Бүтээлээ хурдан хийх зорилгоор, эсвэл олдож байгаа нь энэ юм чинь гэхгүйгээр яаж ийгээд эмэгтэй эх сурвалжийг гаргах гэж хичээх хэрэгтэй юм байна.

**-Эмэгтэй эх сурвалж хэр
олдоцтой байдаг вэ?**

-Салбар салбараараа ондоо л доо. Тухайлбал уул уурхай, эдийн засаг, банк санхүү мэтийн салбарт яах аргагүй эрэгтэйчүүд давамгайлчихаад байдаг. Эрүүл мэнд, боловсрол мэтийн сэдвээр ярих эмэгтэйчүүдийг олоход асуудалгүй. Улс төр судлаачтай ярилцлага хийе гэхээр эмэгтэй судлаач нэлээд ховор санагддаг. Тиймээс эх сурвалжийн дата сан сэтгүүлчдэд хэрэг болно гэдэгт итгэлтэй байна.

Ер нь сэтгүүлчид санаатай гэхээс илүүтэй санамсаргүйгээр эмэгтэйчүүдээс яриа авахыг орхигдуулчихдаг нь нийтлэлээ маш хурдан хугацаанд гаргах ёстой байдагтай холбоотой болов уу. Тэгэхээр олдож байгаа, санаанд хамгийн түрүүнд орж ирдэг нь өмнө нь хэвлэлээр гарчихсан эрэгтэйчүүд байдаг.

**-Сургалтад хамрагдсанаас
хойш өдөр тутмын ажилд нь ямар
өөрчлөлт гарч байгаа вэ?**

-Би сэтгүүлд нийтлэл бичээд дуусахынхаа өмнө харсан чинь эш татсан ихэнх хүмүүс маань эрэгтэй байсан. Тэгээд өөрийгөө нэг талаас зэмлэсэн ч нөгөө талаас улс төрийн салбарт идэвхтэй байдаг, ярьдаг хүмүүс нь эрэгтэйчүүд байгаад байсан. За ямар ч байсан би энд хоёр эмэгтэй эх сурвалж нэмэх хэрэгтэй гээд “Нээлттэй нийгэм форум”-аас нэг судлаач, нэг улс төрч эмэгтэйг шийдвэр гаргагч гэдэгт угтаар нь нэмж оруулж ирсэн.

Одоо цөлжилтийн тухай 30 минутын нэвтрүүлэг хийж байгаа, нэлээд олон эх сурвалжтай. Академич, судлаачдын яриаг түлхүү оруулж байна. Тэгээд би нэвтрүүлгээ төлөвлөхдөө л зорилго тавьсан. Дөрвөн судлаач оруулахаар бол хоёрыг нь эмэгтэй байлгана гэж. Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн салбарын дарга нар ихэнх нь эрэгтэй байдаг юм билээ. Тэгээд бэлчээрийн талаар яриа авахдаа албаны даргатай нь яриад, эмэгтэйчүүд хэвлэлээр бага гардаг учраас эмэгтэй судлаачаас яриа авна гэж тайлбарлаж байж эх сурвалжаа олсон.

Мөн мод тарьж байгаа хүмүүсийг нэвтрүүлэгтээ оруулах байсан. Сэтгүүлч хүн чинь бүтээлээ эхлэхийнхээ өмнө судалгаагаа хийхдээ хамгийн түрүүнд хэвлэлээр энэ тухай юу юу гарсан байна гэдгийг харж, тэндээсээ эх сурвалжаа тодорхойлдог. Ихэнх мод тарьдаг санаачилгыг амжилттай хэрэгжүүлж байгаа гэдгээр эрэгтэй хүнийг гаргасан байсан. Ганцхан хэвлэл дээр ойн ангийг амжилттай ажиллуулж байгаа эмэгтэй лидерийг гаргасан байв. Тэр эмэгтэй дээр очоод сурвалжилгаа хийсэн. Тэгэхээр Монголын цөлжилттэй тэмцэх, мод тарих ажлын нэг хэсгийг эмэгтэй хүн удирдаад явж байгаа шүү гэдгийг харуулах зорилгоо биелүүлсэн гэж бодож байгаа. ■

Мэдрэмжтэй өнцөг: Жендэрийн хэвшмэл ойлголтыг халах нь



Жендэрийн хэвшмэл ойлголт (стереотип) нь эмэгтэй, эрэгтэй хүмүүс, тодорхой бүлгүүдийн шинж төрх, ялгаа, гүйцэтгэх үүргийн тухайд нийгэм соёлын нөлөөгөөр төлөвшин тогтсон хялбаршуулсан ерөнхий ойлголт юм. Жендэрийн хэвшмэл ойлголт нийгэм соёл бүрд харилцан адилгүйгээс гадна цаг хугацааны явцад өөрчлөгддөг боловч эмэгтэйчүүдийн захирагдмал, хамааралтай байр суурийг хадгалж бэхжүүлсэн түгээмэл шинжтэй байдаг. Энэхүү жендэрийн хэвшмэл ойлголт нь аливаа шударга бус байдлыг зөвтгөхийн үндэс болж байдаг.

Жендэр, хэвлэл мэдээллийн харилцаа холбоо талаас фрэймингийн онолоор судалсан олон арван жилийн ажлын үр дүн бидэнд хэвлэл мэдээллээр эмэгтэйчүүдийг хэвшмэл ойлголтын дагуу дүрсэлдгийг баталж байна. Эмэгтэй хүн ээж байна уу, улс төрч байна уу хамаагүй; эхний ээлжинд тэднийг биологийн хүйсээр нь, дараа нь биеэ авч явах байдлаар нь, зөвхөн үүний дараа л (тэгээд хэрвээ энэ нь сэтгүүл зүйн бүтээлд зайлшгүй чухал байвал) тэдний мэргэжлийн албан тушаалынх нь дагуу загварчлан гаргадаг хэмээн “Жендэр, улс төр ба мэдээ: Гурван талын тоглоом” номын зохиогч Карен Росс тайлбарлажээ.



Эмэгтэй улс төрчийг хэвшмэл ойлголтын дагуу харуулдаг нийтлэг таван алдаа

1. Хэвлэл мэдээлэл эмэгтэй улс төрчдийн хувийн амьдралын талаарх дуулиан шуугианыг олон нийтийн эрх ашигт хамааралтай мэтээр сурвалжлан гаргах нь нэмэгдсэн гэж Карен Росс тэмдэглэжээ. Ийм жишээ Монголд ч элбэг гардаг. Тухайлбал, нэг мэдээллийн сайт сошиал хуудсаараа “Эмэгтэйчүүдийг үхтэл нь бамбирдаад хүүхэд гаргуулах хэрэгтэй” гэсэн гарчигтай ярилцлагын сурталчилгаа цацсан бөгөөд БНН-ын дарга Б.Жаргалсайхан УИХ-ын нэгэн эмэгтэй гишүүнийг дөрвөн өөр хүний дөрвөн хүүхэдтэй гэж хэлснийг ямар ч шүүлтүүргүй, нягтлан шалгахгүйгээр олон нийтэд хүргэсэн. Энэ промо нь хүйсээр ялгаварлан гадуурхсан, эмэгтэйчүүдийг дорд үзсэн талаарх иргэний гомдол Хэвлэл мэдээллийн зөвлөлд ирсэн бөгөөд редакц ёс зүйн ноцтой алдаа гаргасныг тогтоосон. Редакц алдаагаа ухамсарлаж, Фэйсбүүк хуудаснаасаа сурталчилгааг устгасан боловч хэдийнэ дуулиан шуугиан дэгдээж амжсан.

2. Эмэгтэй улс төрчдөд элдвээр нэр хоч өгөх стратегийг хэвлэл мэдээлэл мөн түгээмэл ашигладгийг Карен Росс онцолжээ. Их Британийн 1997 оны сонгуулийн үеэр эмэгтэй парламентын гишүүдийн тоо хоёр дахин нэмэгдэхэд тэднийг “Blair’s Babes” буюу Ерөнхий сайд Тони Блэйрийн “хонгорууд” нэршлийг хэвлэл мэдээллийнхэн гаргаж ирсэн байдаг. Монголд ч “Боов”, “Кэндикраш”, “Бенз” гэх мэтээр нэр хоч өгсөн жишээг бид олноор нь мэднэ.

3. Эмэгтэй нэр дэвшигчид, улс төрчдийн гэр бүлийн амьдралыг тодотгож, тэднийг улс төрийн ажлаа ээж, эмээгийн үүрэг хариуцлагатайгаа хавсран хийж чадах эсэхийг асуудаг нь түгээмэл байдгийг профессор Виржиния Гарсия Боудоу онцолжээ. Тухайлбал, АНУ-ын 2016 оны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвших сунгаанд өрсөлдөж байсан Хиллари Клинтоны охин жирэмсэн болсон мэдээллийг хэвлэл мэдээлэл онцолж, эмээгийн үүрэг хариуцлагаа яах талаар сониучирхаж байсан удаатай. Гэтэл бид олон хүүхэдтэй аав, өвөө нараас ийм асуулт асуудаггүй. Монголд ч мөн эмэгтэй улс төрчдийг сайн эхнэр, ээж мөн эсэхийг эхлээд чухалчилж авч үздэг.

4. Хэвлэл мэдээллээр эмэгтэй улс төрчдийг дүрсэлдэг дараагийн нэг загвар нь тэднийг нөлөө бүхий эрчүүдийн дагуул дүрээр гаргах юм. Улс төрч Ц.Оюунгэрэлийг “Ц.Элбэгдоржийн хүн” гэдгээр байнга дурддаг жишээг энд хэлж болно. А.Ариунзаяа, Ч.Номин, С.Одонтуяа нарыг олны танил аав, өвөөгөөр нь овоглодог жишээ ч байна. Эмэгтэй хүн хүүхэд, гэр бүлийн хүрээний хүн, сайн хань, сайн ээж байх ёстой гэсэн хэвшмэл ойлголт байдаг. Тиймээс ч өндөр албан тушаалтай эмэгтэй хүнийг өөрийн чадлаар гарч ирээгүй, ямар нэг нам хүчин, нөлөө бүхий хүний туслалцаатайгаар гарч ирсэн гэх хандлага байдгийг “Глоб Интернэшнл Төв” ТББ-аас эмэгтэй улс төрчдийн талаар хийсэн Хэвлэл мэдээллийн мониторингийн тайланд дүгнэжээ.

5. Түүнчлэн нас, биеийн галбир, төрх, хувцаслалт, нүүр будалт, биеэ авч явах байдал зэрэг эрэгтэй улс төрчдийн талаар дурддаггүй зүйлсийг эмэгтэй улс төрчдийг дүрслэхдээ тоочдог.

Эмэгтэй улс төрчдийг хэвшмэл ойлголтын дагуу тусгадаг сэтгүүл зүйн практикийг өөрчлөхийн тулд улс төрч эмэгтэйчүүдийг улс төрийн байр суурь, үзэл санаа, хийж байгаа ажлаар нь дүрслэх чухал байна. Үүнд, улс төрийн аливаа асуудлаар эмэгтэйчүүдийн санал бодлыг гаргах, мөн эрэгтэй, эмэгтэй улс төрчдөд асуултад хариулах адил тэгш боломж өгөх шаардлагатай. Ардчилсан нийгмийн бусад нийгмээс ялгарах гол онцлог бол цөөнхийг хүндэтгэх явдал байдаг. Эмэгтэй улс төрчид цөөнх гэдэг утгаар тэдний үзэл санааг тусгах нь чухал юм.

Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдтэй холбоотой нийтлэг хүлээлтийг эвдэхүйц сэтгүүл зүйн бүтээлийг хэвшмэл ойлголтыг халсан гэж тодорхойлж байна. Хэвшмэл ойлголтыг халсан сэтгүүл зүйн бүтээл нь аливаа асуудлыг харах шинэ өнцөг, байр суурь, бодолцох шинэ арга замыг олоход тусалдаг гэж Дэлхийн хэвлэл мэдээллийн мониторингийн аргачлалын зааварт тайлбарлажээ. Мониторингийн үр дүнгээс харахад нийт мэдээний ердөө дөрвөн хувь нь л жендэрийн хэвшмэл ойлголтыг халахад чиглэсэн байна.

12 <https://theconversation.com/five-ways-the-media-hurts-female-politicians-and-how-journalists-everywhere-can-do-better-70771>
13 Эмэгтэй улс төрч, эмэгтэй нэр дэвшигчдийн талаар ХМХ-ээр мэдээлсэн нь: Хэвлэл мэдээллийн мониторинг, Глоб Интернэшнл, 2011
14 Тогтмол хэвлэлд 2000, 2008 онд нийтлэгдсэн эмэгтэй улс төрчдийн талаарх нийтлэлийн харьцуулсан судалгаа, 2012 он.
15 Жендэрийн мэдрэмжтэй сурвалжилж бичих нь, “Сэтгүүлч” дээд сургууль, 2015
16 GMMMP Methodology Guide. (2020). Retrieved from Who makes the news?: <https://whomakesthenews.org/>



ЗӨВЛӨМЖ

Сэтгүүл зүйн бүтээлээр дамжуулан жендэрийн хэвшмэл ойлголтыг халах нь



Жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйг амжилттай хэрэгжүүлж байгаа энэ мэт олон амжилттай туршлагыг судалсны үндсэн дээр редакц эх сурвалжийн хүйсийн тэнцвэртэй байдлыг хангахын тулд төлөвлөж судлах, бүртгэл хөтлөх, редакцын ажилтнуудын оролцоог хангах, эх сурвалжуудаа чадавхжуулах гэсэн дөрвөн стратегийн ангилал гарган хийж болох үйл ажиллагаануудыг “Бодит байдлыг тусга” гарын авлагад зөвлөсөн байдаг. Энэ хүрээнд юу хийж болох дэлгэрэнгүй зөвлөмжийг хүргэе.



Эмэгтэй, эрэгтэй хүний нийгэмд эзлэх байр суурь, үүрэг хариуцлагын талаар хүйсээр илтэд ялгаварласан байдлаар тайлбарлахаас зайлсхийгээрэй. Тухайлбал, хүүхэд, эмэгтэйчүүдийн хүчирхийллийн асуудлаар эмэгтэй гишүүд анхаарахгүй байна гэж шүүмжлэх нь зохисгүй. Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах чиглэлд яагаад эрэгтэй гишүүд оролцох ёсгүй гэж?



Ашиглаж байгаа тэмдэг нэрээ анхаараарай. Тухайлбал, охид, эмэгтэйчүүдийг уян зөөлөн, сайхан сэтгэлтэй, хөдөлмөрч, харин хөвгүүд, эрэгтэйчүүдийг зоригтой, шийдэмгий, ажил хэрэгч, гүндүүгүй; эмэгтэйчүүдийг идэвхгүй, эрэгтэйчүүдийг идэвхтэй хэлбэрээр байнга дүрслэхээс зайлсхийгээрэй.



Жендэрийн үүргийг хэвшсэн “эмэгтэйлэг”/“эрэгтэйлэг” шинжээр дүрслэн харуулж, үүнийг хэвийн, хувиршгүй үзэгдэл гэх ойлголт төрүүлэхээс зайлсхийгээрэй. Учир нь ингэснээр эрэгтэй, эмэгтэй хүний нийгэм дэх бусад боломжит шинж чанар, үүрэг хариуцлагыг үгүйсгэх хандлага бий болгодог. Тухайлбал, эрэгтэй хүнийг боловсрол, ажил мэргэжлийн амжилтаар нь, эмэгтэй хүнийг царай зүс, бие галбир, өмссөн зүүснээр нь, эсвэл хэр сайн гэрийн эзэгтэй вэ гэдгээр нь сонжих хандлага ажиглагдсаар байгаа. Улс төрч эмэгтэйн талаар нийтлэл/нэвтрүүлэг бэлтгэхдээ хэдэн хүүхэдтэй, хэр сайн ээж вэ гэдгийг зайлшгүй шаардлагатай биш л бол оруулах хэрэггүй.



Аливаа үйл явдал, сэдэвт эрэгтэй/эмэгтэйчүүдийн оролцоог үнэн бодитоор, цогцоор нь тусгахад анхаарах шаардлагатай. Тухайлбал, УИХ-ын сонгуульд нэр дэвшигч дөрвөн хүн тутмын нэг нь эмэгтэй байхад хэвлэл мэдээллээр гаргасан мэдээллийн хавьгүй бага хувийг эмэгтэй нэр дэвшигчдийн талаарх мэдээлэл эзэлж байгааг судалгаа харуулдаг.



Эрэгтэй, эмэгтэйчүүдийн олон хэмжээст төлөөлөл/дүр төрхийг харуулах гарал үүсэлтэй эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг мэдээний эх сурвалжаар сонгох нь чухал. Зарим сэдэв дээр эмэгтэйчүүд, эсвэл эрэгтэйчүүд огт дурдагддаггүй.

Энэ бүх зөвлөмжийг багцалж дүгнэвэл бид хэвлэл мэдээллээр эмэгтэйчүүдийн талаарх хэвшмэл ойлголтыг халахын тулд хоёр үндсэн стратегийг хэрэглэж болохоор байна. Үүнд:

- Өөрсдөөр нь яриулах. Эмэгтэйчүүдийг яриулж байж асуудлыг олон талаас гаргаж ирнэ.
- Байдлыг эргүүлж тавих. “Хэрвээ энэ улс төрч эрэгтэй байсан бол би гэр бүлийн байдал, хувцаслалт, үс засалт, нүүр будалтыг нь гаргах байсан уу?” гэдгийг бодолцох нь зүйтэй. Тухайлбал, эмэгтэй улс төрч өөрөө эх хүн гэдгээ ярьж эхлээгүй л бол сэтгүүлч асуух шаардлагагүй юм.



Зураг дүрсээ мөн анхаараарай

Сэтгүүл зүйн бүтээлд ашиглаж байгаа зураг, дүрс ч мөн эмэгтэйчүүдийг хэвшмэл ойлголтын дагуу гаргах нь түгээмэл байдаг. Тухайлбал:

-Эрэгтэйчүүдийг ажил хэрэгч байдлаар, ихэвчлэн албан тушаалтан, улс төрч дүрээр, харин эмэгтэйчүүдийг албаны бус зургаар, ихэвчлэн энгийн иргэн, ээж, гэргий, мэргэжилтний хувьд илүүтэй дүрсэлдгийг судалгаа харуулжээ.

-Эмэгтэй хүний биеэ авч явах байдал, хувцаслалт, нүүр будалт зэрэгт илүү ач холбогдол өгч гаргах;

-Эрэгтэй улс төрчийг инээмсэглэсэн, нүдэнд дулаахан байдлаар, эмэгтэй улс төрчийг хүйтэн, догшин харцтайгаар гаргах нь элбэг байдгийг "Women in News" байгууллагаас гаргасан Жендэрийн тэнцвэрт байдлын удирдамжид онцолжээ.

Мөн өдөр тутмын сонин, мэдээллийн сайтуудын улс төрийн буланд эмэгтэй улс төрчдийн зураг маш цөөн байдаг. Тиймээс дээрх бүх алдааг гаргахгүйн тулд эмэгтэй улс төрчийн зургийг мэдрэмжтэйгээр авч, хэвлэл мэдээлэлд гаргаж байх нь чухал.



Women in News



ЗӨВЛӨМЖ

Эмэгтэй улс төрчийн хөрөг зургийг хэрхэн мэдрэмжтэйгээр авах вэ?



Эмэгтэй улс төрчийн хөрөг зургийг хэрхэн мэдрэмжтэй, чанартай авах тал дээр Марейке Гюньше багшийн зөвлөгөөг та бүхэнд хүргэж байна. Марейке Берлинд фото сэтгүүлчээр ажиллаж байсан, Ханновер, Берлин, Хамбургт гэрэл зурагчнаар суралцаж төгссөн. Тэрбээр 2009 оноос Монголд ажиллаж, амьдарч байсан туршлагатай бөгөөд эдүгээ Их Британийн Лондон хотод оршин суудаг. Монгол дахь Гёте-Институт Соёл урлагийн их сургуультай хамтран мэргэжлийн гэрэл зурагчны ангийг 2019 оноос нээхэд Марейке зочин багшаар ажиллаж байв.



Цаг хугацаа харамгүй зарцуулаарай. Учир нь сайн хөрөг зураг их цаг шаарддаг. Зураг авахуулах хүнтэйгээ аль болох өмнө нь уулзаж, бие биеэ таньдаг болох нь зүгээр. Тухайн хүн танд итгэж байвал хөрөг зураг илүү сайн болно.



Байрлалдаа анхаар. Сэтгэл зүйн хувьд зурагны зүүн тал өнгөрснийг, харин баруун тал ирээдүйг илтгэдэг болохыг санаарай. Үүнийг илүү хүчирхэг хөрөг зураг авахын тулд ашиглах нь зүйтэй. Нэг бол эмэгтэйд зурагны фрэймийнхээ баруун талд байхаар, үгүй бол түүний бие, эсвэл нүүр царай бага зэрэг баруун тийш харах байрлал сонгоорой. Яг л эмэгтэй алхаж эхэлбэл зурагны фрэймийг баруун тийш нэвтэлж гарах мэт харагдахаар байхад болно. Гэхдээ үүнийг хэтрүүлэн хийж болохгүй шүү. Түүний нүүр ерөнхийдөө тан руу, үзэгчид рүү харж байх хэрэгтэй.



Хэрэв улс төрч эмэгтэй сууж байгаа бол түүнийг сандлаа налах биш, нуруугаа цэх суухыг зөвлөөрэй.



Цаг гаргаж, түүний зургийг сууж байгаа, зогсож байгаа аль алинаар нь авахаа мартуузай. Мөн түүнийг гартаа брошюр, үзэг, эсвэл нүдний шил ч юм уу барьж байгаагаар зураг авах нь тустай байж магадгүй.





Эмэгтэйн гар зурганд харагдах нь чухал шүү. Түүнийг гараа халаасандаа хийх, эсвэл ардаа нууж болохгүйг сануулаарай.



Бүх бие нь багтсан байх зайнаас, тал бие нь харагдах байдлаар, мөн нүүр царайг нь ойроос авсан хөрөг зураг авч, голон зургийн сонголт гаргахаар ажиллаарай. Бүтэн биеийн зураг авахдаа түүний хөлийг тасалж болохгүй. Тал биеийн зураг авахдаа өвдөгнөөс доогуур тасалж хэзээ ч болохгүй, өвдөгнөөс дээгүүр тасалж аваарай. Учир нь, хүний зургийг өвдөгнөөс доогуур тасалж авснаар тухайн хүн гацсан мэт сэтгэгдэл төрүүлдэг бол түүнээс дээш тасалснаар энэ асуудлыг тойрч болдог.



Зургийн арын хэсэгт юу байгааг шалгаарай. Анхаарал сарниулах, үймүүлэх зүйлсээс зайлсхийх нь чухал.




Улс төрч эмэгтэйд хөрөг зургаа хаана авахуулмаар байгааг нь, түүнд дуртай газар бий эсэхийг асуугаарай. Түүнд аюулгүй, тухтай газрыг сонгож чадвал хөрөг зураг илүү хүчтэй болно. Хэрвээ түүнд дуртай ороолт, зүүлт ч юм уу байдаг бол тэрийгээ ороож, зүүхийг санал болгоорой. Тэгвэл улс төрч эмэгтэйд илүү тухтай, аятайхан мэдрэмж төрж, зураг нь ч сайхан гарах болно.



Зургийн перспектив асар чухал. Хөрөг зургийг нэг бол нүдний шугамын перспектив, эсвэл нүдний шугамаас бага зэрэг дооших перспективээс аваарай. Өөрөөр хэлбэл, та камераа улс төрч эмэгтэйн нүдтэй нэг өндөрт, эсвэл түүнээс арай доогуур, тухайлбал эрүүнийх хэмжээнд байхаар тохируулаарай. Улс төрч эмэгтэй рүү бага зэрэг доороос дээш харах байдлаар авах нь түүнийг илүү хүчирхэг харагдуулах болно. Гэхдээ мөн л үүнийг хэтрүүлж болохгүй. Хэрэв хэтрүүлбэл улс төрч эмэгтэй биеэ тоосон, ихэрхүү харагдаж мэднэ. Улс төрч эмэгтэйн зургийг хэзээ ч дээрээс доош харж байгаа перспективээс авч болохгүй. Учир нь, энэ нь сул дорой харагдуулах байрлал бөгөөд үзэгчид түүн рүү доош харж буй мэт сэтгэгдэл төрж, түүнийг эмзэг байдлаар харагдуулах болно.



Зураг авах гэж байгаа газар, эсвэл өрөөний байгалийн гэрэл хаанаас яаж тусаж байгааг ажиглаарай. Хэрвээ өрөөнд том цонх байвал гэрлийг нь хөрөг зургаа авахуулж буй эмэгтэйн нүүр лүү тусах байдлаар зохион байгуулаарай. Хэрвээ та флаш гэрэл хэрэглэж байгаа бол шууд бусаар, таазан дээр ойгоод арай зөөлөн болох байдлаар ашиглах нь зүйтэй.



Өөрчлөлтийн эхлэл: Жендэрийн тэгш байдлыг хангахад “хоточ нохойн” үүрэг гүйцэтгэх нь



“Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” хэмээн Монгол Улсын Үндсэн хуульд заасан нь жендэрийн тэгш байдлыг хангах эрх зүйн орчны үндэс суурь болдог. Мөн Монгол Улс 1946 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1954 оны Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн конвенц, 1981 оны Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцид нэгдэж, эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засаг, улс төрийн эрхийг хамгаалах амлалт өгсөн. Энэ бүх үүрэг амлалтыг биелүүлэхэд хэвлэл мэдээллийн салбар нэн чухал үүрэг гүйцэтгэх шаардлагатай.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон жендэрийн тэгш байдалд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хянах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд хэвлэл мэдээллийн салбар онцгой үүрэг гүйцэтгэх учиртай. Жендэрийн тэгш байдал, тэгш эрхийн талаарх мэдээ, сурвалжилга нь хэвлэл мэдээллийн гүйцэтгэдэг нийгмийн “хоточ нохойн” үүргийн салшгүй, чухал хэсэг юм. Энэ үүргээ гүйцэтгэж чадахгүй бол нэг л мэдэхэд 2030 он болчихсон, бид тогтвортой хөгжлийн зорилтоо биелүүлээгүй сууж байна. Мянганы хөгжлийн зорилтын хүрээнд Монгол Улс 2015 он гэхэд УИХ дахь эмэгтэйчүүдийн суудлыг 30 хувьд хүргэнэ гэсэн амлалт өгсөн боловч 2012 оны сонгуулиар УИХ дахь эмэгтэйчүүдийн тоо өсөөд, өсөөд амлалтынхаа талд нь ч хүрээгүй гашуун туршлага бидэнд бий. Энэ бүхнийг өөрчлөх эхлэлийг чухам хэвлэл мэдээлэл л тавьж чадна.

Аженда-сеттингийн онолоор хэвлэл мэдээлэл нь олон нийтийн анхаарлаа хандуулах үйл явдал, асуудлыг сонгож танилцуулдаг гэж үздэг. Жишээ нь, өнөөдөр Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээс аль нь “Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо” гэсэн сэдвийг чухалчлан үздэг вэ? Улс төрийн аливаа мэдээний агуулгад энэ асуудал ямар нэг байдлаар тусдаг уу? Эсвэл тусгай булан байдаг уу? Яг энэ асуудлыг хэлэлцэх сэдэв болгосон уу гэх мэтээр асуудлыг нарийвчлан хэмжиж, энэ сэдэв нь тухайн хэвлэл мэдээллийн аженда байж чадаж байгаа эсэхийг гаргаж ирж болно.

Улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх нь хүний үндсэн эрхийг хангах, төлөөллийн ардчиллыг бэхжүүлэх, хөгжлийн зөв бодлогод нөлөөлөх зэрэг олон асуудлыг хамарсан чухал сэдэв юм. Гэвч олон улсын хэмжээнд болон Монголд энэ сэдвийг хэвлэл мэдээлэл барьж авч сурвалжлахдаа хойрго байна.

Дэлхийн хэвлэл мэдээллийн мониторингийн судалгааны үр дүнг харахад нийт мэдээллийн ердөө зургаан хувь нь жендэрийн тэгш/тэгш бус байдлын талаар мэдээлжээ. Энэ нь улс төр, эдийн засгийн сэдвээс бага жин дарж байгааг судлаачид онцолсон байна.

Тэгвэл Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс 2021 онд сэтгүүл зүйн бүтээлийн агуулгад хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд өдөр тутмын сонин, сайтуудын улс төрийн мэдээллийн нийт агуулгын ердөө 1.8 хувьд л жендэрийн тэгш/тэгш бус байдлын талаар дурджээ.

Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо сэдвийг олон улсын хэмжээнд хангалттай мэдээлж, сурвалжлахгүй байгаа ч сэдвийн ач холбогдол, орон зайг олж харсан санаачилгууд өрнөж байгаа юм.



Энэтхэгийн Жендэр, хэвлэл мэдээлэл ба сонгуулийн ажиглагч

Энэтхэгийн Хэвлэл мэдээлэл дэх эмэгтэйчүүдийн сүлжээ байгууллагаас “The Gender, Media and Election Watch” (Жендэр, хэвлэл мэдээлэл ба сонгуулийн ажиглагч) нэртэй блог хөтөлж иржээ. Энэ нь хэвлэл мэдээллийн байгууллагууд, сэтгүүлчид сонгуулийг мэдээлэхдээ эмэгтэйчүүдийн асуудал, эмэгтэй сонгогчид, нэр дэвшигчдийг хэрхэн төлөөлж/эс төлөөлж байгаад жендэрийн линзээр дүн шинжилгээ хийх зорилготой. Мөн улс төрийн намууд болон нэр дэвшигчид эдгээр асуудалд хэрхэн хандаж байгааг ажиглаж, анализ хийдэг байна.¹⁹

Америкийн The 19th сайт

АНУ-ын нэр хүндтэй “Texas Tribune” хэвлэл мэдээллийн байгууллагын ерөнхий эрхлэгч Эмили Рамшоу, олон нийтийн эрхлэгч Аманда Замора нар 2020 онд “The 19th” нэртэй бие даасан, ашгийн бус редакц үүсгэн байгуулсан. Тэд улс төр, жендэрийн асуудлыг хэвлэл мэдээлэл хэрхэн мэдээлж, сурвалжилдаг арга замыг өөрчлөх зорилготой бөгөөд АНУ-ын эмэгтэйчүүдэд сонгох, сонгогдох эрхийг олгосон Үндсэн хуулийн 19-дх нэмэлт, өөрчлөлтөөс санаа авч нэрээ өгчээ. Мөн нэрний баруун дээд буланд алтан гадас одон байрлуулж өгсөн нь ардчиллаас гээгдсэн хүмүүс байгааг сануулах, тэдний дуу хоолой болж ажиллахыг илтгэж байгаа аж.²⁰

Монголын mpress.mn сайт

Олон жилийн туршлагатай, салбартаа танигдсан редакторууд mpress.mn сайтыг үүсгэн байгуулсан бөгөөд редакцын бодлогодоо шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийг дэмжиж ажиллахаа тусгасан байна.



19
20

„Gender, Media and Election Watch, n.d.
<https://19thnews.org/>



MPRESS.MN САЙТЫН РЕДАКЦЫН БОДЛОГЫН ХЭСГЭЭС

Mpress.mn сайт нь улс төр болон бизнесийн ашиг сонирхлоос ангид байж, иргэдийн дуу хоолой болж, сэтгүүл зүйн зарчмаар ажиллана.

Бид нийгмийн цөөнхийн дуу хоолойг орхигдуулахгүй байх тал дээр хичээнгүйлэн ажиллаж, эх сурвалжийн тэнцвэртэй байдалд үргэлж анхаарна.

Mpress.mn сайт нь улс төр, эдийн засаг, нийгмийн мэдээлэл зонхилсон, уншигч, үзэгчдэд мэдээ мэдээллийг сэтгүүл зүйн мэргэжлийн түвшинд,

 Үзэх

 Сонсох

 Унших

Хэлбэрээр хүргэдэг мэдээллийн хэрэгсэл /мэдээллийн сайт/ юм.

АГУУЛГА:

Агуулгын хувьд бид улс төр, эдийн засгийн салбарын агуулгад түлхүү анхааран ажиллана. Агуулгын даацтай, уншууртай, дүн шинжилсэн байдалд илүүтэй ач

холбогдол өгнө. Манай редакцын бодлого, агуулгууд дараах цэснүүдээр та бүхэнд хүрэх болно.

УЛС ТӨР: Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ

Манай сайт нь редакцын бодлогоороо шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэн ажиллах болно. Бид эмэгтэй улс төрчид, манлайлагчдыг эрчүүдтэй эн тэнцүү авч үзэн, тэдний бодлого, үйл ажиллагаа, зорилтын талаар түлхүү мэдээлж байхыг эрмэлзэнэ. “Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо”-г 2021 оны нөхцөл байдлаас нэмэгдэх хүртэл бид энэ бодлогоо хэрэгжүүлж ажиллана.

Үүний зэрэгцээ улс төрийн салбарт өрнөж буй үйл явдлын талаарх мэдээ, нийтлэл, сурвалжилгыг та бүхэндээ цаг алдалгүй хүргэхэд зорин ажиллана...

УЛС ТӨР:

Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ

Манай сайт нь редакцын бодлогоороо шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэн ажиллах болно. Бид эмэгтэй улс төрчид,

манлайлагчдыг эрчүүдтэй эн тэнцүү авч үзэн, тэдний бодлого, үйл ажиллагаа, зорилтын талаар түлхүү мэдээлж байхыг эрмэлзэнэ. “Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо”-г 2021 оны нөхцөл байдлаас нэмэгдэх хүртэл бид энэ бодлогоо хэрэгжүүлж ажиллана.

Үүний зэрэгцээ улс төрийн салбарт өрнөж буй үйл явдлын талаарх мэдээ, нийтлэл, сурвалжлагыг та бүхэндээ цаг алдалгүй хүргэхэд зорин ажиллана...

ЭДИЙН ЗАСАГ:

Иргэн баян бол улс баян

Эдийн засгийн буланд бид шаардлагатай үнэ ханшийн мэдээллүүдийг өдөр тутамд шинэчлэн оруулж байхаар хичээн ажиллах болно.

Энэ булангаас та бүхэн валют, криптовалюта, таваар, үл хөдлөх хөрөнгө, хөрөнгийн биржийн хувьцааны үнэ ханшийн талаарх мэдээллийг авах боломжтой.

Түүнчлэн эдийн засгийн салбарын мэргэжилтнүүдийн ярилцлага, нийтлэлүүдийг хүлээн аваарай.

НИЙГЭМ, БОЛОВСРОЛ-ын цэснүүдээс та бүхэн холбоотой мэдээлэл, сэтгүүл зүйн бусад бүтээлийг хүлээн авах боломжтой...

-Өгөгдөл цуглуулах;

-Юуг хянаж чадахаа хэмжих;



mpress.mn

Тэгш эрхийн төлөө...



О.АРИУНБИЛЭГ:

**Бид контент бүрдээ
жендэрийн тэгш байдлыг
анзааран ажиллах болно**

Mpress.mn сайтын үүсгэн
байгуулагч О.Ариунбилэгтэй товч
ярилцсаныг хүлээж авна уу.

-Монголын хэвлэл мэдээллийн салбар хэт олон тоглогчтой, өрсөлдөөн ихтэй. Шинэ, мэргэжлийн редакцын хувьд цаашдаа хэрхэн бусдаас ялгарч, өсөж хөгжихөөр зорьж байна вэ?

-Монголын хэвлэл мэдээллийн салбар хэдий олон тоглогчтой мэт тоо харагдавч, мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг нь цөөхөн. Мөн ёс зүй, дүрэмтэй нь бүр цөөн. Тиймээс бид нэгдүгээрт, мэргэжлийн үйл ажиллагаатай, олон талын тэнцвэртэй мэдээлэлтэй, хянуур, ёс зүйн дүрэмтэйгээрээ ялгарна. Хоёрдугаарт, манай редакц зөвхөн мэдээлэл түгээгээд зогсохгүй салбарынхаа шинэ залуу сэтгүүлчдийн мэдлэгийг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд анхаарч ажиллах болно. Энэ нь тэднээр дамжаад нийгэмд өгөх боловсролын контент байх болно.

-Mpress.mn сайт улс төрийн агуулгын хувьд шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарна гэж редакцын бодлогодоо тусгаж, зарласан Монголын анхны хэвлэл мэдээллийн байгууллага гэж харж байгаа. Яагаад үүнийг онцлон зорих болов?

-Хэдийгээр редакц маань шинэ боловч, удирдлагууд нь хэвлэл мэдээллийн салбарт олон жил ажилласан туршлагатай. Өмнөх



Бид редакцынхаа бодлогын хүрээнд эмэгтэй улс төрчид, эмэгтэй манлайлагчдыг үргэлж дэмжин ажиллах болно.



ажил дээрээ жендэрийн тэгш байдал, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаар цөөнгүй контент нийтэлж байсан. Энэ туршлага дээрээ үндэслэн нийгэм, улс төрийн амьдралд нэн шаардлагатай байгаа энэ бодлогыг зориуд редакцын бодлогодоо тусгасан. Энэ бодлогынхоо хүрээнд бид эмэгтэй улс төрчид болон эмэгтэй манлайлагчдыг үргэлж дэмжин ажиллах болно.

-Дээрх зорилгодоо хүрэхийн тулд хэрхэн, яаж ажиллахаар

төлөвлөж байна вэ?

-Өдөр тутмын үйл ажиллагаандаа бид контент бүрдээ жендэрийн тэгш байдлыг анзааран ажиллах болно. Түүнчлэн, манай редакц 2024 оны сонгууль хүртэл эмэгтэй манлайлагчдыг дэмжин ажиллаж, тэдний дуу хоолойг уншигчдадаа хүргэх, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдсэнээр нийгэм улс оронд нааштай ямар өөрчлөлтүүд гарч болох талаарх мэдээллүүдийг тогтмол хүргэсээр байх болно.

-Сэтгэгдлийн хэсгийг зохицуулна гэдгээ mpress.mn мөн бодлогодоо оруулсан нь шинэлэг санагдлаа. Үүнийг хэрхэн хийж байгаа вэ?

-Монголын мэдээллийн сайт бүхэн “Сэтгэгдэл бидэнд хамаагүй, бид хариуцлага хүлээхгүй” гэх санамжийг сэтгэгдлийн хэсэгт багтаасан байдаг. Сэтгэгдлийг сайтаас гадуур бичээгүй буюу тухайн сайтын талбарт бичиж байгаа учир үүнийг редакц журмаараа заавал зохицуулах ёстой. Тиймээс бид сэтгэгдлийн хэсгийг анхаарч, хууль зөрчсөн, хүний нэр хүндэд халдсан, худал мэдээлэл тараасан зэрэг тохиолдолд тухайн сэтгэгдлийг устгах хүртэлх бүх төрлийн арга хэмжээ аван ажиллах болно. ■





Улс төр дэх жендэрийн эрх тэгш байдлыг хангахад ямар алдаа дутагдал байгааг судалж, оношилж гаргах нь чухал. Үүний тулд тухайн сэдвийг сайн мэдэх мэргэжилтнүүдэд хамгийн түрүүнд хандаж, зөвлөгөө аваарай. Тэд таны бүтээлийн чухал эх сурвалж болохоос гадна сэдвийнхээ өнцгийг тодорхойлох, хэрэгтэй дата мэдээллээ олж авах, бусад эх сурвалжтай холбоо тогтооход тус дэм болж чадна. Жендэрийн үндэсний хороонд хандан жендэрийн үндэсний шинжээчдийн холбоо барих мэдээллийг авч болно. Мөн Монфемнет үндэсний сүлжээ, Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд зэрэг төрийн бус байгууллагад ажилладаг мэргэжилтнүүд, их дээд сургуулийн багш, судлаачдад хандах нь тохиромжтой. Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс улс төр, эдийн засаг, уул уурхай, технологи, хөдөө аж ахуйн чиглэлээр ярих эмэгтэйчүүд болон жендэрийн асуудлаар ярих эрэгтэй эх сурвалжийн дата мэдээллийг авах боломжтой.



Хүйсийн ялгаатай байдлыг бий болгож буй улс төр, эдийн засаг, нийгэм соёлын нөхцөл байдал, хүчин зүйлүүдийн талаар судалж, тоон болон чанарын мэдээллүүдийг цуглуулан дүн шинжилгээ хийх нь чухал. Үүнийг хийх хамгийн хялбар бөгөөд үр дүнтэй арга нь жендэрийн чиглэлээр гарсан судалгааны тайлангуудыг гарчиглах юм. Эдгээр судалгаа нь маш их хэмжээний чухал мэдээллийг агуулдаг ч олон нийтэд төдийлөн хүрээгүй байдаг учраас шинэ өнцөг, хадаас сэдэв эрж олох боломж үргэлж байдаг. Та дараах цахим хуудаснуудаас ач холбогдолтой судалгааны тайлан, дата мэдээллийг авах боломжтой:

- o Жендэрийн үндэсний хорооны <https://ncge.gov.mn/> цахим хуудасны “Ном хэвлэл”, “Судалгаа” цэс
- o Жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг мэдээллийн платформ <https://genderhub.mn/>
- o Статистикийн мэдээллийн нэгдсэн сан <https://1212.mn/>



Олон нийт, шийдвэр гаргагчдын анхаарлыг илүү их татаж, илүү нөлөө үзүүлэхийн тулд редакцаас төлөвлөсөн тусгай эрэн сурвалжилга, дата сэтгүүл зүйн бүтээл зэргийг гаргаж болно. Ийм нийтлэл, нэвтрүүлгээ аль болох оргил цаг/эхний нүүр зэрэгт онцгойлон гаргахад анхаараарай.



Жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйн чиглэлээр дотоодын болон олон улсын байгууллагууд шилдэг бүтээл шалгаруулах уралдаан, тэтгэлэг зэргийг элбэг зохион байгуулах болсон. Ийм боломжуудын талаар мэдээлэлтэй байж, сэтгүүлчдээ оролцохыг дэмжиж байгаарай. “Мэдрэмжтэй мэдээлье” нэгдлийн гишүүн болж, фэйсбүүк групп болон пэйж хуудсыг дагаснаар шинэ боломжуудын талаар мэдээллийг хялбар авах боломжтой.



“Мэдрэмжтэй мэдээлье” редакцын менторшип хөтөлбөр



Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс “Мэдрэмжтэй мэдээлье” редакцын менторшип хөтөлбөрийг 2022 оны зургаадугаар сараас хэрэгжүүлсэн бөгөөд GoGo.mn мэдээллийн сайт, “Зууны мэдээ” сонины хамт олныг эхний ээлжинд амжилттай хамруулаад байна. Энэхүү хөтөлбөр нь редакцын удирдлагад бодлогын болон менежментийн зөвлөгөө өгч, хэвлэл мэдээллийн салбарт ялгарч, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, BBC-ийн 50:50 төсөл, “Internews”-ийн “Бодит байдлыг тусга” санаачилга болон олон улсын бусад амжилттай туршлагаас судлах, суралцах, хамтран ажиллах боломжийг нээж өгөх зорилготой байв. Мөн баг, хамт олны мэргэжлийн, ёс зүйн ур чадварыг дээшлүүлж, жендэрийн мэдрэмжтэй өнцгөөс мэдээлж, сурвалжлах, хэвлэл мэдээллийн бүтээлийн агуулга дахь жендэрийн тэгш бус байдал, хэвшмэл ойлголтыг халах мэдлэг, ур чадвар олгоход чиглэсэн.

Эх сурвалжаа төрөлжүүлэх урт хугацааны үр дүнтэй, ашиглахад хялбар аргачлал нэвтрүүлснээр уншигч, үзэгч, сонсогчдоо бүрэн гүйцэд төлөөлөхүйц чанартай бүтээлийн төрөл, хэлбэрийг төлөвшүүлж, иргэдийн хэвлэл мэдээлэлд итгэх итгэлийг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулна гэдэгт бид итгэдэг. Ингээд “Мэдрэмжтэй мэдээлье” редакцын менторшип хөтөлбөрт хамрагдсан хоёр редакцын туршлагатай танилцацгаая.

GoGo.mn олон ургалч байр суурийг хүргэх “Тэнцвэр”
санаачилгыг эхлүүлж байна



gogo
MONGOLIA

Дэлхийн хүн амын тэн хагасыг бүрдүүлдэг эмэгтэйчүүдийн дуу хоолойг хэвлэл мэдээллээр маш бага хүргэдгийг Та мэдэх үү? Олон улсын хэвлэл мэдээллийн мониторингийн үр дүнгээс үзэхэд хэвлэл мэдээллээр гарч байгаа дөрвөн хүн тутмын нэг нь л эмэгтэй байна. Мөн эмэгтэйчүүдийг ихэвчлэн ээжийн үүргээр дүрсэлдэг бөгөөд улс төр, эдийн засаг зэрэг салбарт мэргэжлийн байр суурийг нь хүргэх тохиолдол хангалтгүй байгаа юм. Байдал энэ чигээр үргэлжилбэл мэдээний агуулгаас жендэрийн тэгш байдлыг харахын тулд дор хаяж 67 жил хүлээх хэрэгтэйг судлаачид анхааруулдаг.

Гэвч бид тэр цагийг хүлээж, зүгээр суухгүй. Мэдлэг, боловсролоороо манлайлдаг монгол эмэгтэйчүүдийнхээ байр суурь, үзэл бодлыг уншигчдадаа хангалттай сайн хүргэх нь манай контентыг илүү үнэ цэнтэй болгоно гэж GoGo.mn үзэж байна. Мөн хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлыг хангахад анхаарч, нийгмийг чиглүүлэх, түүчээлэх үүргээ гүйцэтгэх нь манай редакцын бодлогын салшгүй чухал хэсэг билээ. Тиймээс ч бид “ТЭНЦВЭР” санаачилгыг эхлүүлж, бодлого, үйл ажиллагаандаа шинэчлэл хийж байгаагаа мэдэгдэж байна. Энэ хүрээнд хийж байгаа ажлаа эрхэм уншигчдадаа танилцуулъя.



БИД НЭГ АЛХАМ УРАГШИЛЛАА

Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс өнгөрсөн онд хийсэн судалгаанаас үзэхэд өдөр тутмын сонин, сайтуудын улс төрийн мэдээний арван эх сурвалж тутмын ганц нь л эмэгтэй байна.

Тэгвэл Хэвлэл мэдээллийн зөвлөлийн төслийн баг GoGo.mn сайтын контентод /мэдээ, нийтлэл, ярилцлага, сурвалжилга/-д мониторинг хийхэд нийт эх сурвалжийн 30 гаруй хувийг л эмэгтэйчүүд бүрдүүлж байв. Тиймээс ч бид мэдээллийн агуулгадаа жендэрийн эрх тэгш байдлыг бүрдүүлэх зорилгоор “Мэдрэмжтэй мэдээлье” редакц чадавхжуулах, менторшип хөтөлбөрт хамрагдсан. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд бид Хэвлэл мэдээллийн зөвлөлийн сургагч багш нараас гурван өдрийн сургалт авч, редакцын хамт олныхоо жендэрийн мэдрэмжтэй байдлыг сайжрууллаа.

Мөн олон улсын “Интерньюс” байгууллагын “Бодит байдлыг тусга” санаачилгын нөөц хэрэглэгдэхүүн болох эх сурвалжийн бүртгэлийн хуудсыг хөтөлж эхлээд байна. Үүний үр дүнд хөтөлбөр эхлэхэд эмэгтэйчүүд нийт эх сурвалжийн 30 хувийг бүрдүүлж байсныг 38 хувь хүртэл нэмэгдүүллээ. Бид эх сурвалжийн хүйсийн тэнцвэрт байдлыг хангах үүднээс үүнийг 40 хувьд хүргэх зорилготой ажиллаж байгаа юм.



БИД ОЛОН УЛСЫН ХӨДӨЛГӨӨНД НЭГДЭЖ БАЙНА

Нийгэм, эдийн засаг, бизнесийн гээд бүхий л салбарт дэлхий нийт жендэрийн эрх тэгш байдлыг чухалчилж буй. Дэлхийн томоохон редакцууд ч үйл ажиллагаандаа энэ төрлийн хэв маягийг нэвтрүүлж эхлээд байна. GoGo.mn BBC-ийн 50:50 төсөлтэй албан ёсоор түншилсэн Монголын анхны мэдээллийн сайт болсноо дуулгахад таатай байна. Энэхүү түншлэлийн хүрээнд бид BBC өөрийн контентод эмэгтэйчүүд төдийгүй үндэстний болон бэлгийн цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дуу хоолойг амжилттай нэмэгдүүлэхдээ хэрэглэсэн аргачлалыг нэвтрүүлэн ашиглахаар төлөвлөж байна. Бид эх сурвалжийн хүйсийн тэнцвэрт байдлыг мэдээ, нийтлэлдээ төдийгүй цаашлаад зурган өгүүлэмжид ч хангахыг эрмэлзэж байна.

Баталгаатай бөгөөд сонирхолтой эх сурвалж болохуйц эмэгтэй мэргэжилтнүүд хөшигний цаана ихэвчлэн үлдэж байсан. Харин одоо энэ байдлыг халж тэднийг “тайзан” дээр гаргаж ирэн үг хэлэх боломж олгох хэрэгтэй. Нийгмийн нэг талыг бүхэлд нь төлөөлж байгаа эмэгтэйчүүдийн үгс, дуу хоолойг бусадтай эн тэнцүү түгээх зорилготой бидний санаачилга амжилттай хэрэгжихэд BBC-ийн 50:50 төсөл дэм болно гэдэгт итгэлтэй байна.



БИД ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ЧУХАЛЧИЛНА

Жендэрийн тулгамдаж буй асуудлыг бодит баримттайгаар олон нийтэд мэдээлж, шийдвэр гаргагчдын түвшинд хүргэн тэдний анхаарлыг хандуулж, тодорхой өөрчлөлт хийх цаг нь ирсэн. Энэ бол зөвхөн нэг редакцын зорилго байгаад зогсохгүй хэвлэл мэдээллийн салбарын бусад байгууллагын үйл ажиллагааны нэг чиглэл болсноор илүү амжилттай хэрэгжих боломжтой билээ.

Бид цаашлаад цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй бүлгийн дуу хоолойг хүргэх бөгөөд дээрх санаачилгын хүрээнд бусад редакцтай туршлагаа хуваалцаж, хамтрахдаа нээлттэй байх болно.



Р.АДЪЯАСҮРЭН:

Бүртгэл хөтөлж эхэлснээр бид үнэлж, дүгнэж, өөрчлөх боломжтой болсон

GoGo.mn
мэдээллийн сайтын
ерөнхий редактор
Р.Адъяасүрэнтэй
менторшип
хөтөлбөрийн
талаар ярилцлаа.

**“Мэдрэмжтэй мэдээлье”
менторшип хөтөлбөрийн
редакцад оруулсан гол хувь
нэмрийг ярьж өгнө үү?**

-Манай редакцын зүгээс сэтгүүлчдээ энэ чиглэлийн сургалтад тогтмол хамруулсаар ирсэн. Дотоод журмын дагуу сургалтад хамрагдсан сэтгүүлчид сурсан мэдсэн зүйлсээ бусдадаа хуваалцдаг, тэр дагуу мэдээлэл авдаг байсан. Харин энэ удаад бүгд хөтөлбөрт хамрагдсанаар нэг ойлголттой болсон нь давуу тал юм. Өдөр тутамд оруулж буй мэдээ, нийтлэл, сурвалжилгынхаа эх сурвалжийн хүйсийн тэнцвэртэй байдалд бүгд ижил оролцоотойгоор анхаарал хандуулж, юуны төлөө зорьж байгаа, энэ нь яагаад чухал

гэдгийг олж харсан нь хамгийн чухал байлаа. Мөн хүйсийн төдийгүй эх сурвалжийн түвшний тэнцвэрийг хэрхэн хангаж байгаа талаар бүртгэл хөтөлж эхэлснээр бид сэтгүүл зүйн бүтээлүүдээ үнэлж, дүгнэж, өөрчлөх боломжтой болсон. BBC-ийн 50:50 төслийн албан ёсны түнш болсон нь мөн л бидэнд чухал байсан. Бид өөрсдөө эх сурвалжийнхаа хүйсийн тэнцвэрт байдлыг хадгалах зорилгоор “Тэнцвэр” санаачилгыг эхлүүлсэн гээд хөтөлбөрийн хувь нэмрийг дурдвал их олон зүйл бий.

-Менторшип хөтөлбөрийн үеэр нэвтрүүлсэн ажлуудыг цаашдаа танай редакц хэрэгжүүлээд явахаар байна уу?

-Бид хөтөлбөрийн үеэр нэвтрүүлсэн ажлуудаа тасралтгүй авч явахын тулд хариуцсан сэтгүүлчидтэй болгосон. Одоогийн байдлаар хөтөлбөрөөс олж авсан мэдлэг, санаануудаа бүтээлдээ тогтмол тусгаж хэвших нь хамгийн чухал байна. “Тэнцвэр” санаачилгынхаа хүрээнд нийт эх сурвалжийнхаа 40-өөс дээш хувийг эмэгтэйчүүдээр бүрдүүлэх зорилгодоо хүрэхийн тулд өдөр тутамдаа, сар бүр үнэлэлт дүгнэлт хийх, түүнээс үүдэн дараагийн алхмуудаа тодорхойлоод явна гэж төлөвлөж байна. ■

“Зууны мэдээ” сонин эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжин ажиллана

Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс “Мэдрэмжтэй мэдээлье” редакц чадавхжуулах хөтөлбөрөөр дамжуулан редакцуудыг BBC-ийн 50:50 төслийн хамтрагч болоход нь гүүр болж, улмаар жендэрийн мэдрэмжтэй редакцын бодлоготой болох, эх сурвалжийн дата санг арвижуулахад анхаарч ажиллав. Мөн редакцын сэтгүүлчдэд сургалт зохион байгуулж, Монгол Улсад тулгамдсан жендэрийн асуудлуудын талаар бичихэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн юм.

Редакц чадавхжуулах хөтөлбөр сургалтболонхоёрсарынхугацаатай менторшип гэсэн үе шаттай байв. Энэ оны зургаагаас наймдугаар сард “Зууны мэдээ” сонин “Хэвшмэл ойлголтоо өөрчилъё” булан нээж, жендэрийн асуудлыг тогтмол, цуврал болгон бичиж эхэллээ. Манай сонин хөтөлбөр хэрэгжих хоёр сарын хугацаанд жендэрийн тэгш байдлын чиглэлээр 10 бүтээл гаргасан байна.

Ингэхдээ бид мэргэжил сонголтод хүйс хамааралгүй гэсэн өнцгийг тодотгон, эрэгтэй хүний мэргэжил, эмэгтэй хүний



мэргэжил гэсэн хэвшмэл ойлголтыг өөрчлөхийг зорилоо. Тодруулбал, жудочин охидод тулгардаг асуудлыг онцолсон “Спортоор хичээллэхэд хүйс хамааралгүй” нийтлэл, “Автобусны жолооч эмэгтэйн ажлын нэг өдөр”, “IT-д цахиур хагалах охид”, “Монгол туургатны хэмжээнд 22 эмэгтэй хөөмийч бий”, “Батлан хамгаалах салбарт эмэгтэй удирдагч үгүйлэгдэж байна”, эрэгтэй сувилагчийг онцолсон “10 мянгад нэг тохиох эрэлттэй мэргэжлийн эзэн” зэрэг бүтээлийг уншигчдадаа хүргэжээ. Эдгээр нийтлэлээрээ бид “Эрэгтэй хүн л сайн уурхайчин, шилдэг удирдагч, чадварлаг программист байдаг. Эмэгтэйчүүд балет, бүжгээр хичээллэж гэрийн сайн эзэгтэй, ээж байх ёстой. Мөн сувилагч эмэгтэй, жолооч эрэгтэй байх нь зөв” гэсэн хэвшмэл ойлголтыг өөрчлөхийг зорилтоо болгосон юм.

Үүнээс гадна хөтөлбөрийн хүрээнд үндэсний өдөр тутмын

“Зууны мэдээ” сонин редакцын бодлогоо шинэчлэн баталж, нийтлэлийн агуулгадаа нийгмийн бүхий л хэсгийн дуу хоолой, үзэл санааг хүргэж, эх сурвалжийн хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах, ялангуяа хүн амын 50-иас дээш хувийг эзэлж буй эмэгтэйчүүдийн оролцоог шийдвэр гаргах түвшинд нэмэгдүүлэхэд чиглэн ажиллахаар боллоо. Бид эмэгтэй улс төрчид, бизнес эрхлэгчид, манлайлагчдыг эрэгтэйчүүдтэй эн тэнцүү авч үзэн, тэдний бодлого, үйл ажиллагаа, зорилтын талаар адил тэгш мэдээлж байхыг эрмэлзэнэ хэмээн редакцын бодлогодоо тусгаад байна.

Хөтөлбөрийн хүрээнд бид редакцын бодлогоо шинэчилж, жендэрийн мэдрэмжтэй нийтлэлүүд гаргахын зэрэгцээ BBC-ийн тэгш байдлын 50:50 төслийн албан ёсны түнш болж, хамтран ажиллаж эхлээд байна. Ингэснээр манай сонин өдөр тутмын нийтлэлийнхээ эх сурвалжийн хүйсийг бүртгэн, эрэгтэй эмэгтэй эх сурвалжийнхаа тоог тэнцвэржүүлэх, эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжих чиглэлд ажиллах юм.





Х.МӨНХЖАРГАЛ:

Жендэрийн эрх тэгш байдлыг хангахаар нийтлэлийн бодлогодоо тусгасан



“Зууны мэдээ” сонины хариуцлагатай нарийн бичгийн дарга Х.Мөнхжаргалтай ярилцлаа.



Жендэрийн мэдрэмжтэй байх, эх сурвалжийн датагаа өргөжүүлэх, гурван түвшний эх сурвалжаа байнга барьж явахад анхаарна.



-Та бидэнд “Мэдрэмжтэй мэдээлэл” менторшип хөтөлбөрийн редакцад оруулсан хувь нэмрийг ярьж өгнө үү?

-Манай сонины редакц энэ хөтөлбөрт хамрагдаж мэргэжлийн хувьд нэг шат ахиж чадсандаа баяртай байгаа. Бид менторшип хөтөлбөрт хамрагдсанаар сонинхоо нийтлэлийн бодлогоо шинээр гаргахдаа жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай тусгасан. Сонины хөл дээр нийтлэлийн бодлогоо QR кодтой болгон уншигчдадаа хүргэж байгаа.

Мөн дугаар болгондоо эх сурвалжийнхаа хүйсийн тэнцвэртэй байдалд анхаарч ажилладаг болсон. Эх сурвалжийн дата бүрдүүлж, өдөр бүр хөтөлдөг. Өглөөний шуурхай дээр эх сурвалжийн хүйсийн харьцаа, эх сурвалжийн гурван түвшинг хэрхэн хангаж байгаагаа ярилцаж, дүгнэж байна.

Түүнчлэн “Хэвшмэл ойлголтоо өөрчилье”, “Эмэгтэйчүүдийн манлайлал” гэсэн хоёр булан шинээр нээж, долоо хоног тутамд тогтмол материалууд нийтэлж эхэллээ. Хамгийн гол нь ВВС телевизийн 50:50 төслийн түнш болсон нь бидний хувьд том дэвшил болсон.

-Жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүйн чиглэлээр редакцын хувьд цаашдаа юу хийх төлөвлөгөөтэй байгаа вэ?

-Бид хөтөлбөрөөс сурсан мэдсэнээ өдөр тутамдаа хэрэгжүүлж, үйл ажиллагаандаа суулгах тал дээр онцгойлон анхаарч ажиллаж байна. Жендэрийн мэдрэмжтэй байх, эх сурвалжийн датагаа өргөжүүлэх, гурван түвшний эх сурвалжаа байнга барьж явахад анхаарна. Жендэрийн мэдрэмжтэй, мэдлэг мэдээлэлтэй хамт олон байж, цаашид ур чадвараа улам ахиулна.

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Жендэрийн нэр томъёоны товч тайлбар

ХҮЙС гэдэг нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн биологийн болон генетикийн хувьд ялгагдах шинжүүдийг хамаарсан ойлголт юм. Эдгээр шинж нь/мэсажилбар болон дааврын эмчилгээнээс бусад тохиолдолд/ хувирч өөрчлөгддөггүй гэдгээрээ нийтлэг байдаг.

ЖЕНДЭР гэдэг нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хувьд нийгмээс бий болгосон хэм хэмжээ, үүрэг, дүр төрх, нийгмийн хандлагын ялгааг хамаарах ойлголт юм. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд жендэр гэдэг нь улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг хэлнэ хэмээн тодорхойлжээ.

ЖЕНДЭРИЙН ХЭВШМЭЛ ОЙЛГОЛТ/ ҮЗЭЛ (СТЕРЕОТИП) нь эмэгтэй, эрэгтэй хүмүүс, тодорхой бүлгүүдийн шинж төрх, ялгаа, гүйцэтгэх үүргийн тухайд нийгэм соёлын нөлөөгөөр төлөвшин тогтсон хялбаршуулсан ерөнхий ойлголт юм. Жендэрийн хэвшмэл ойлголт нийгэм соёл бүрд харилцан адилгүйгээс гадна цаг хугацааны явцад өөрчлөгддөг боловч эмэгтэйчүүдийн захирагдмал, хамааралтай байр суурийг хадгалж бэхжүүлсэн түгээмэл шинжтэй байдаг. Энэхүү жендэрийн хэвшмэл ойлголт нь аливаа шударга бус байдлыг зөвтгөхийн үндэс болж байдаг.

ЖЕНДЭРИЙН ХЭМ ХЭМЖЭЭ гэдэг нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хувьд хийж болох, болохгүй зүйлсийн талаарх нийгмийн хүлээлт юм.

ЖЕНДЭРИЙН ҮҮРЭГ, ДҮР ТӨРХ гэдэг нь тухайн нийгэм, хамт олон, нийгмийн бүлгийн хувьд ямар үүргийг оноож, ямар дүр төрхийг эрэгтэйлэг, эмэгтэйлэг гэж үздэгийг харуулах ойлголт юм.

ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ нь тухайн нийгэмд тодорхой үнэ цэнэ бүхий бүтээгдэхүүн, боломж, нөөц, урамшууллыг эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эдлэх ба хүртэх боломжтой байх тухай ойлголт. Гэхдээ орчин цагт жендэрийн тэгш байдлыг эмэгтэй, эрэгтэй хүмүүст ялгаатай хандах бус, харин нөхцөл байдал, боломжийг нь адил тэгш болгоход анхаарах явдал гэж ойлгох болсон. Өөрөөр хэлбэл, энэ нь эрэгтэй эмэгтэй хүмүүс биологийн хувьд өөр өөрийн онцлогтой ч тэдний эдлэх боломж бололцоо нь тэгш, нийгэм, гэр бүлдээ эзлэх байр суурь, эрх үүрэг нь адил байх тухай ойлголт юм.

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖ нь эмэгтэй эрэгтэй хүмүүс, нийгмийн бүлгүүдийн ялгаатай хэрэгцээг, мөн тэдний хөгжлийн үйл явцад оролцох болон үр шимийг нь хүртэхэд хязгаарлалт болж буй хүчин зүйлсийг анхаарч тооцох хүсэл эрмэлзэл, мэдлэг, чадвар юм.

ЖЕНДЭРИЙН ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд болон аливаа бусад салбарт эрэгтэй, эмэгтэй хүнийг хүйсийн шинж, гэрлэлтийн байдлаар ялгаварлах, үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ гэж Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заажээ. Жендэрийн тэгш бус байдал, ялгаварлан гадуурхалт нь жендэрт суурилсан хүчирхийлэлд нөлөөлөгч хүчин зүйлсийн нэг.

ЖЕНДЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ²² гэдэг нь бодлого төлөвлөлт, үйл ажиллагаа нийгмийн янз бүрийн бүлгийн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хэрэгцээнд суурилсан эсэхийг, оролцох болон үр ашиг хүртэх тэгш боломжийг тэдэнд бий болгож байгаа эсэхийг үнэлэн судалж, анхаарч тооцох үйл явц юм.

21 WACC/IFJ. (2012). Learning Resource Kit for Gender-Ethical Journalism and Media House Policy. Book 1. Toronto.

22 Женнифер Мадж, Ж. Ц. (2014). Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах нь: Сургагч багшид зориулсан гарын авлага.

Хавсралт 2. Редакцын жендэрийн мэдрэмжтэй байдлыг үнэлэх чеклист ²¹

ХАМРАХ ХҮРЭЭ

» Нийгмийн оролцогчийн хувьд сэтгүүл зүйн мэргэжлийн ёс зүй, хэвлэл мэдээллийн үүрэг хариуцлагын агуулгад жендэрийн асуудлыг бодлогоор тодорхой тусгасан уу?

» Арьс өнгө, яс үндэс, гарал угсаа, хүйс, нас, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэнд, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг, гэр бүлийн байдал зэргээс үл хамааран хүн бүрд хүндэтгэлтэй хандаж, ялгаварлан гадуурхахгүй байх хүний үндсэн эрхийг хангахыг сэтгүүлчдээс бодлогоор шаарддаг уу?

РЕДАКЦ ДАРААХ БОДЛОГЫГ БАРИМТЛАХЫГ ШААРДДАГ УУ?

» Бүх мэдээллийг жендэрийн мэдрэмжтэйгээр мэдээлэх

» Мэдээллийг/асуудлыг жендэрийн мэдрэмжтэйгээр илүү гүнзгий нарийн судалгаатай гаргах байнгын асуудал хөндсөн нийтлэл/хадаас нийтлэл эсвэл нэвтрүүлэг хийх

» Мэдээллийг/асуудлыг жендэрийн мэдрэмжтэйгээр илүү гүнзгий нарийн судалгаатай гаргах байнгын асуудал хөндсөн нийтлэл бичих даалгаврыг эрэгтэй, эмэгтэй сурвалжлагчдад тэгш хуваарилах

» Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг тэгш, шударга хамруулах

» Одоогийн явагдаж байгаа болон байгууллагын мэргэжлийн хөгжлийн сургалтад жендэрийн мэдрэмжтэй байдлын талаарх сургалт, ойлголтыг нэгтгэх

» Жендэр болон шинээр гарч ирж буй асуудлуудын талаар сурвалжлагч, редакторуудыг тасралтгүй сургалтад хамруулах

НИЙТЛЭЛИЙН ЭХ СУРВАЛЖ/ЯРИЛЦАГЧ, ШИНЖЭЭЧИД

Бодлогоор шаардах:

» Ярилцлага авсан хүмүүсийн хүйсийн харьцаа нь мэдээлэл хүрсэн хэвлэл мэдээллийн үзэгч/уншигчийн жендэрийн харьцааг илэрхийлж байна уу?

» Мэдээлж буй асуудлын талаар мэддэг иргэний нийгмийн байгууллагуудтай зөвлөлддөг үү?

» Эрэгтэй, эмэгтэй эх сурвалжуудад үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж олгохыг онцгойлон анхаарч, хүчин чармайлт гаргадаг уу?

ЭМЭГТЭЙ, ЭРЭГТЭЙ ХҮМҮҮСИЙН ТӨЛӨӨЛӨЛ, ДҮРСЛЭЛ

Бодлогоор шаардах:

» Эмэгтэйчүүдийг олон талт байдал, давуу тал, нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын амьдралын бүхий л салбарт оролцох оролцоог харуулсан байдлаар дүрслэх

» Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн харилцааг жендэрийн эрх тэгш байдал, хүндэтгэлтэй хандах, ялгаварлан гадуурхахгүй байхыг дэмжсэн байдлаар дүрслэх

» Сэтгүүлчид сэдвийг жендэрийн хэвшмэл ойлголтоор харахаас татгалзах

» Сэтгүүлчид хүйсээр ялгаварлан гадуурхах, доош нь хийжээс татгалзах

ҮГ, ХЭЛЛЭГ

Бодлогоор шаардах:

» Тодорхой, ойлгомжтой үг хэллэг хэрэглэх удирдамж боловсруулж хэрэгжүүлэхийг шаардах:

» Нийгмийг хамарсан, хүйсээр ялгаварлан гадуурхахгүй нэр томъёоны талаар жишээтэй зааварчилгаа өгөх

» Редакцын бодлогын хүрээнд сексист (хүйсээр илт ялгаварлан гадуурхсан) үг хэллэг хэрэглэхгүй байх талаар тодорхой, ойлгомжтой байр суурьтай байх

ЗУРАГ

Бодлогоор шаардах:

» Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд болон бусад хүмүүсийн зургийг нийтлэхээс өмнө зөвшөөрөл авах

» “Хохирол, гэм хорыг багасгах” зарчмыг ялангуяа эмгэнэлт явдал, золгүй явдал тохиолдсон эмэгтэйчүүдийн зурганд баримтлах

» Гэрэл зураг авахдаа ёс зүйн хариуцлага хүлээх

» Гэрэл зургийн сэтгүүлчдэд жендэрийн мэдрэмжтэй зургийн сургалт хийх

» Зөвхөн жендэрийн хэвшмэл ойлголт агуулаагүй контент бүхий зургуудыг нийтлэхээр хүлээн авах

» Зургийн талаарх үзэгчдийн санал хүсэлтийн тандалт, дүн шинжилгээг шинэ чиглэл хандлагыг мэдээлэхэд ашиглах

ТЕЛЕВИЗИЙН КОНТЕНТ

Бодлогоор шаардах:

» Нэвтрүүлгийн цаг нь үзэгчдийн цаг ашиглалтын хэв маягтай холбоотой жендэрийн ялгааг харгалзан үзэх

» Үзэгчдийн санал хүсэлт, дүн шинжилгээг шинэ чиглэлийг мэдээлэхэд ашиглах

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Бодлогоор шаардах:

- » Хэвлэн нийтлэхийг зөвшөөрч болох материалын стандарт нь жендэрийн асуудлыг харгалзсан редакцын стандарттай нийцэх
- » Хэвлэн нийтлэхийг зөвшөөрсөн зар сурталчилгаа нь жендэрийн хэвшмэл ойлголт бүхий контент агуулаагүй байх
- » Тодруулга шаардлагатай тохиолдолд тухайн материал нь жендэрийн мэдрэмжийн стандартыг хангаж байгаа эсэхийг тодорхойлохын тулд жендэрийн мэргэжилтнүүдтэй зөвлөлдөх

БУСАД

- » Аль нэг заалтыг зөрчсөн тохиолдолд торгууль, шийтгэлийн тухай тодорхой заасан уу?
- » Бодлогын хэрэгжилтийг хариуцах хэлтэс, албан тушаалтныг тодорхойлсон уу?
- » Асуулга, лавлагаа авах боломжтой хэлтэс, албан тушаалтныг дурдаж өгсөн үү?
- » Асуулга, лавлагаатай ажиллах үүрэгтэй хэлтэс, албан тушаалтныг тодорхойлсон уу?
- » Гомдол гаргах журмыг тодорхой заасан уу?

Хавсралт 3. Сэтгүүл зүйн бүтээлийн чанарыг хянах редакторын чеклист

- 1.** Жендэрийн линз ашигласан уу?
- 2.** Шинэ дата, судалгаа багтаасан уу?
- 3.** Баримт бичиг, судалгааны эх сурвалжаас гадна аман эх сурвалж, ярилцлагыг зохистой ашигласан уу?
- 4.** Гурван түвшний аман эх сурвалжийн ярианаас эш татсан уу?
- 5.** Хэвлэл мэдээлэлд “үл үзэгдэгч” байдаг эмэгтэйчүүдийн дуу хоолойг хүргэх тал дээр хангалттай хүчин чармайлт гаргасан уу?
- 6.** Жендэрийн хэвшмэл ойлголтыг халсан уу?
- 7.** Ялгаварлан гадуурхсан, сексист, үзэн ядах үг хэллэгээс татгалзсан уу?
- 8.** Энгийн иргэдэд ойлгомжтой үг хэллэг, нэр томъёо ашигласан уу?
- 9.** Хангалттай контекст мэдээлэл, дүн шинжилгээ агуулсан уу?
- 10.** Лийд сонирхолтой байна уу?

Хавсралт 4. Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим ²³

Монгол Улсын Үндсэн хуульд заасан үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхийг хамгаалан бататгаж, Монголын сэтгүүл зүйн хэм хэмжээ нь хүний эрх, хэвлэлийн эрх чөлөөний олон улсын хэм хэмжээг сахин мөрдөж буйг энэхүү ёс зүйн зарчмаар илэрхийлж байна.

Ёс зүйн зарчмууд

1. Олон түмэнд үнэнд нийцсэн мэдээлэл хүргэх, хүнлэг ёс, хүн чанарыг эрхэмлэх нь сэтгүүл зүйн эрхэм дээд үнэт зүйл мөн. Мэдээллийг нягтлах нь сэтгүүл зүйн нягт, нямбай үйл ажиллагааны үндсэн зарчим болно.

2. Мэдээллийг шударга бус аргаар олж авахгүй.

Удирдамж/тайлбар

1.1 Мэдээлэл нь үнэнд нийцсэн эсэхийг баталгаажуулж, санамсаргүй алдаа гаргахаас зайлсхийнэ.

1.2 Эх сурвалжийн баталгаатай эсэхийг нягталж, тодорхой дурьдахыг эрмэлзэнэ.

1.3 Бүтээлийн гарчиг, зураг, дүрс, дуу, график, ишлэл зэрэг нь агуулгыг буруугаар ойлгуулах, хэт хялбарчлах, мэдээллийг нөхцөл байдлаас салгаж мушгин гуйвуулах ёсгүйг үргэлж санаж, ийм зөрчил гаргахгүйн төлөө ажиллана.

1.4 Фото, видео, аудио мэдээллийн агуулгыг техникийн арга хэрэгслээр гуйвуулахгүй.

1.5 Нөлөөллийн болон мэдээллийн бүтээлийг ялгаж, мэдээнд үзэл бодол оруулахаас татгалзана.

1.6 Баталгаагүй мэдээлэл, таамаглал, ам дамжсан яриаг таамаг хэмээн тодорхой дурьдана.

1.7 Хэвлэлийн мэдээг өөрчлөлтгүйгээр нийтэлж, нэвтрүүлбэл редакцийн агуулгаас ялгаж тэмдэглэнэ.

1.8 Буруутгагдсан, шүүмжлэгдсэн этгээдэд тайлбар өгөх боломж олгоно.

1.9 Нийтэлж, нэвтрүүлсэн мэдээлэл нь ташаа болох нь тогтоогдсон мэдээллийг нэн даруй залруулна.

2.1 Сэтгүүлч өөрийгөө танилцуулж, ил тодоор ажиллах нь энэхүү мэргэжлийн үндсэн зарчим болно. Зөвхөн олон нийтийн эрх ашгийг хамгаалах зорилго бүхий, өөр аргаар олж авах боломжгүй мэдээллийг бусад аргаар авч болно.

2.2 Хувийн гэрэл зураг, дүрс бичлэгийг ашиглах тохиолдолд тухайн хүний болон насанд хүрээгүй хүмүүсийн асран хамгаалагчийн зөвшөөрлийг авна.

2.3 Өөрийгөө хамгаалах чадваргүй буюу бусдаас хамаарал бүхий хүнээс мэдээлэл, гэрэл зураг авахдаа мэдрэмжтэй хандана. Энэ нь юун түрүүнд оюун санааны болон бие махбодийн хувьд өөрийгөө захирах чадваргүй, сэтгэл санааны хүнд байдалд орсон хүнд хамаарна.

2.4 Насанд хүрээгүй хүнээс зөвхөн эцэг, эх асран хамгаалагчийнх нь зөвшөөрөлтэйгөөр мэдээлэл авч болно.

3. Хэнийг ч арьс өнгө, яс үндэс, гарал угсаа, хүйсийн байдал, нас, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэнд, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг, гэр бүлийн байдлаар нь ялгаварлан гадуурхалтын золиос болгохгүй.

4. Аливаа мэдээллийг зохисгүй хэлбэрээр дуулиантайгаар түгээхээс татгалзана.

5. Мэдээллийг мушгин гуйвуулах, бусдыг гүтгэх, доромжлох, мэргэжлийн давуу байдлаа урвуулан мэдээллийг хувийн зорилгод ашиглахгүй. Мөн мэдээлэх, эс мэдээлэхийн тулд аливаа хэлбэрийн авлига авахаас татгалзана.

3.1 Гэмт хэргийн талаар мэдээлэхдээ тухайн хүний харьяалал шашин, үндэс угсаа, бусад цөөнхийн төлөөлөл рүү зөвхөн тухайн хэргийг ойлгоход маш чухал тохиолдолд хэрэглэнэ.

3.2 Хэвлэл мэдээллийнхэн нийгэмд оршиж байгаа хэвшмэл ойлголтуудыг улам дэвэргэхээс зайлсхийнэ.

4.1 Гэмт хэрэг үйлдэгдсэн аргыг нарийвчлан харуулсан нийтлэл, нэвтрүүлэг хийхээс зайлсхийнэ.

4.2 Шүүх гэм буруутайг нь нотлоогүй бол хэнийг ч гэм буруутай гэж үзэхгүй.

4.3 Гэмт этгээдийн талаар үлгэрлэн дууриах, шүтэх өнгө аясаар нийтэлж, нэвтрүүлэхгүй.

4.4 Золгүй явдал, осол, хүчирхийллийн талаарх зураг, дүрсийг мэдээлэхдээ тухайн зураг, дүрс нь хүүхэд, өсвөр үеийнхэнд хэрхэн нөлөөлөх магадлалыг харгалзана.

4.5 Гамшиг, осол, гэмт хэргийн улмаас хохирогсдын цогцсыг нарийвчлан харуулахгүй.

4.6 Осол, гамшиг, гэмт хэргийн зураг, дүрсийг нийтэд хүргэхдээ тухайн хэргийн золиос, түүний ойр дотныхон болон хүүхэд, өсвөр үеийнхэнд уг дүрс хэрхэн нөлөөлж болохыг харгалзаж, онцгой няхуур бөгөөд мэдрэмжтэй хандана.

5.1 Гуравдагч талын санхүүжилтээр аялалд хамрагдсан бол аяллын тухай мэдээлэлд санхүүжилтийн талаар тодорхой дурьдана.

6. Хувийн нууцад хүндэтгэлтэй хандана.

6.1 Хэргийн сэжигтэн этгээдийн нэр, хувийн мэдээлэл болон зургийг бусдад танигдахуйц байдлаар нийтэлж, нэвтрүүлэхдээ хувь хүний эрхийг хамгаалах шаардлагыг харгалзана.

6.2 Зөвхөн олон нийтийн тусын тулд хүний нэр, зураг болон бусад хувийн мэдээллийг нийтэд ил болгоно.

6.3 Олон нийтийн тусын тулд гэдэг ойлголтыг “олон нийтэд сонирхолтой” мэдээлэлтэй эндүүрч болохгүй.

6.4 Гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хүний нэр, хувийн бусад мэдээллийг нийтэд дэлгэхгүй.

6.5 Гэмт хэрэг, ослын хохирогчид нэр, нас, албан тушаал болон бусад хувийн мэдээллээ хамгаалуулах эрхтэй.

6.6 Бие болон сэтгэл санааны эмгэг, эрүүл мэндийн тухай мэдээлэл нь хувийн нууцад хамаарах бөгөөд тухайн хүний болон асран хамгаалагчийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэлж, нэвтрүүлэхийг цээрлэнэ.

6.7 Амиа егүүтгэх тохиолдлыг харуулах, нэн ялангуяа нэрийг нь дурьдах, дүрс, нөхцөл байдлыг нь нарийвчлан харуулахаас зайлсхийнэ.

6.8 Тухайн мэдээлэлтэй шууд холбоотой биш л бол гэмт хэргийн сэжигтэн, золиос, хүчирхийлэл, осол гамшигт өртөгсдийн гэр бүл, ойр дотны хүмүүсийн овог нэр, ажил, албан тушаал, гэрэл зураг, дүрсийг тэдний зөвшөөрөлгүйгээр нийтэлж, нэвтрүүлэхгүй.

7. Бусдын уй гашуу, зовлон шаналалд хүндэтгэлтэй хандана.

8. Мэдээллийн нууц эх сурвалжаа чандлан хамгаална.

9. Төлбөрт нийтлэл, нэвтрүүлгийг тусгай тэмдэг, тэмдэглэгээгээр ялгана.

10. Хэвлэл мэдээлэл нь сонгуулийн санал хураалтаас өмнө буруутгагдсан этгээдийг тайлбар хийх боломжгүй хугацаанд нэрдэвшигчийн талаар мэдээлэл түгээхээс зайлсхийнэ.

9.1 Далд зар сурталчилгааны аливаа хэлбэрээс татгалзана.

- (n.d.). *Portraying Politics, a toolkit on gender and television.*
- 50:50 The Equality Project. (2021). *Impact Report.*
- BBC. (n.d.). *Diversity and Inclusion Strategy 2016-20.*
- Council of Europe. (2017). *Media, Elections and Gender: Study on media coverage of elections with a specific focus on gender equality.*
- European Institute for Gender Equality. (2012-2014). *European Institute for Gender Equality: <https://eige.europa.eu/gender-mainstreaming/good-practices/ireland/irish-current-affairs-programme-gives-women-equal-place>*
- Fourth World Conference on Women. (1995). *The Beijing Declaration and the Platform for Action . Beijing.*
- Gender, Media and Election Watch. <https://nwmigenderwatch.wordpress.com/>
- GMMP. (2020). *Who Makes the News.*
- ICFJ. (2019). *The State of Technology in Global Newsrooms.*
- Internews, United for News. (n.d.). *Reflect Reality.*
- IPU. (2021, October 9). Retrieved from <https://data.ipu.org/women-ranking?month=9&year=2021>
- Kassova, L. (2020). *The Missing Perspectives of Women in News.* Bill & Melinda Gates Foundation.
- UN Women, IDEA. (2011). *The Election Coverage from a Gender Perspective, a Media Monitoring Manual.*
- WACC/IFJ. (2012). *Learning Resource Kit for Gender-Ethical Journalism and Media House Policy.* Toronto.
- Women in News. (2020). *Amplifying women's voices A Gender Balance Guide For Media.*
- World Economic Forum. (2021). *Global Gender Gap Report 2021.*
- Б.Дулмаа, М. (2020, III). Монгол эмэгтэйчүүд ойкосын хүрээнээс полисын тавцанд гарсан нь. *Жендэр судлал, 70-79.*
- Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн. (2021). *SheVotes Mongolia: Эмэгтэйчүүд, залуучуудын улс төрийн оролцоонд тулгарч буй саад бэрхшээлүүд.*
- Г.Гүнжидмаа. (2020). Сэтгүүл зүйн ба нийгмийн хэвлэл мэдээллийн бодлогын жендэрийн мэдрэмжид хийсэн үнэлгээ зөвлөх үйлчилгээний тайлан . *Улаанбаатар.*
- Д.Мөнхчимэг. (2021). Жендэрийн мэдрэмж, ёс зүйтэй сэтгүүл зүй: Редакцуудад зориулсан удирдамж . *Улаанбаатар.*
- Д.Мөнхчимэг, Ц.Чимэддондог (2018). “Цахим сайтууд дахь үзэн ядах үг хэллэг” контент анализын судалгаа. *Фридрих-Эбертийн-Сан.*
- Жендэрийн үндэсний хороо. (2018). *Жендэр ба бодлого төлөвлөлт.*
- Женнифер Мадж, Ж. Ц. (2014). Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах нь: *Сургагч багшид зориулсан гарын авлага.*
- Л.Бямбаханд (2020). Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хязгаарлагч хүчин зүйлс. . Т. б. зөвлөл-Д, Монгол дахь ардчилал, иргэний нийгмийн өнөөгийн байдлын нийгэм-улс төрийн судалгаа (хуудсд. 25-61). *Улаанбаатар.*
- Хэвлэл мэдээллийн зөвлөл. (2020). *Сонгуулийг ёс зүйтэй сурвалжлах бодлогын баримт бичиг.*
- Хэвлэлийн хүрээлэн. (2017). *Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх сэтгүүлчдийн ойлголт, редакцийн бодлого, сэтгүүл зүйн практик.*
- Цогц хөгжлийн үндэсний төв. (2021). *Улс төр дэх залуучууд болон эмэгтэйчүүдэд тулгамдаж буй сорилт бэрхшээл судалгааны тайлан.*
- Э.Гэрэлт-Од, Д. (2020, III). Монгол Улсын Их Хурал дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл, сорилт. *Жендэр судлал, 80-85.*
- ЮНЕСКО, Глоб Интернэшнл Төв. (2014). *Хэвлэл мэдээлэл дэх жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлт.*

